



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бүс Аудиторын Тайлан

Премиум Нэксус Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Премиум Нэксус ХК (цаашид “Толгой Компани” гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь “Групп” гэх)-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бүс Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бүс байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 25, мөн Тодруулга 3-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
Группийн хувьд орлого хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт нь харьцангуй энгийн боловч, жижиглэн худалдааны салбарын өндөр өрсөлдөөнөөс шалтгаалан орлогыг зориуд, системтэйгээр буруугаар тайлагнах, хүлээн зөвшөөрөх эрсдэл байж болзошгүй гэж үзсэн. Ялангуяа, франчайз эрх хүлээн авагч болон зарим охин компаниудын эцсийн хэрэглэгчдэд борлуулсан борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн хувьд уг эрсдэлийг харгалзан үзсэн. Үнэт цаасны зах зээлийн оролцогч олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд, дотоод болон гадаад оролцогч талуудын санхүүгийн гүйцэтгэлийн хүлээлтээс үүдэлтэйгээр төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалт Группийн хувьд үүсэж болзошгүй гэж үзсэн. Энэ нь борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэхтэй холбоотой уламжлалт эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй ба ялангуяа франчайз дэлгүүрүүд бодитоор оршин байгаа эсэх, зарим охин компаниудын эцсийн хэрэглэгчдэд борлуулсан борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэхэд уг эрсдэлийг авч үзсэн. Дээрх зүйлстэй холбоотойгоор бид франчайз дэлгүүрүүд болон зарим охин компаниудын эцсийн хэрэглэгчдэд борлуулсан борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.	Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд: - Бид удирдлагын зүгээс борлуулалт болон борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх үйл явцад хэрэгжүүлж буй хяналтууд, тэр дундаа франчайз дэлгүүрүүдийн борлуулалтын орлого бодитоор оршин байгаа эсэх, хүлээн зөвшөөрөлт нь үнэн зөв эсэхийг тодорхойлдог хяналтуудыг шалгасан. - Бид Группийн франчайз эрх хүлээн авагчдаас олсон орлогыг шалгах үүднээс франчайз эрх хүлээн авагчид руу захидал илгээн тулган баталгаажуулах аудитын горим гүйцэтгэж, шалгасан. - Бид Группийн зарим охин компаниудын борлуулалтын орлогын шалгах үүднээс тэдний харилцагчид руу захидал илгээн тулган баталгаажуулах аудитын горим гүйцэтгэж, шалгасан. - Бид удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдээс тухайн тайлант жилд залилантай холбоотой орлого хүлээн зөвшөөрөлт болон хэвийн бүс ажил гүйлгээ гарсан эсэх талаар ярилцлага хийсэн. - Бид борлуулалтын орлогыг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалган, холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан.



Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд аливаа материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид энэ талаар тайлагнах үүрэгтэй. Бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агүүлж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.



Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны үлмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны үлмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид Группийн аудитыг гүйцэтгэх, хянах, удирдах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.



Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бүүрүүлсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Жу Сан Ён, аудитын компанийн Ерөнхий Захирал нь Г. Соёлмаа нар болно.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

Баталгаажуулсан:

Г. Соёлмаа
Ерөнхий Захирал

Баталсан:

Жу Сан Ён
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Премиум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	9	118,133,460	84,451,983
Ашиглах эрхтэй хөрөнгө	10	60,568,629	50,532,242
Биет бус хөрөнгө ба гүүдвил	11	39,774,043	5,744,456
Санхүүгийн түрээсийн авлага	12	10,031,970	8,238,816
Зээлийн авлага	13	47,049	-
Урьдчилгаа	15	2,580,879	770,655
Дансны ба бусад авлага	16	2,381,209	2,160,078
Хойшлогдсон татварын хөрөнгө	31	1,985,220	1,426,574
Нийт эргэлтийн бус хөрөнгө		235,502,459	153,324,804
Эргэлтийн хөрөнгө			
Зээлийн авлага	13, 36	27,599	2,000,000
Бараа материал	14	47,194,508	28,250,029
Урьдчилгаа	15	7,326,359	1,761,313
Дансны ба бусад авлага	16, 36	10,329,858	3,675,977
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	17, 36	10,431,533	2,980,585
Санхүүгийн түрээсийн авлага	12, 36	3,119,136	1,502,377
Нийт эргэлтийн хөрөнгө		78,428,993	40,170,281
НИЙТ ХӨРӨНГӨ		313,931,452	193,495,085
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	18	111,425,203	81,776,864
Нэмж төлөгдсөн капитал	18	45,757,916	13,820,503
Эздийн өмчийн бусад хэсэг		318,731	318,731
Хуримтлагдсан алдагдал		(63,586,419)	(110,184,780)
Группийн хувь эзэмшигчдэд ногдох өмч		93,915,431	(14,268,682)
Хяналтын эрхгүй хувь оролцоо		8,873,378	-
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		102,788,809	(14,268,682)
ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат өр төлбөр			
Түрээсийн өр төлбөр	10	64,535,185	56,622,145
Зээл	19, 36	23,389,243	33,882,015
Засгийн газрын тусламж	20	498,904	-
Бусад урт хугацаат өр төлбөр		1,834,721	709,269
Гэрээний өр төлбөр	24	43,388	117,781
Хойшлогдсон татварын өр	31	4,598,558	259,675
Нийт урт хугацаат өр төлбөр		94,899,999	91,590,885
Богино хугацаат өр төлбөр			
Түрээсийн өр төлбөр	10, 36	17,695,275	12,079,710
Зээл	19, 36	24,733,230	19,969,946
Засгийн газрын тусламж	20	627,087	-
Бусад татварын өглөг	22	2,138,926	1,669,598
Дансны ба бусад өглөг	23, 36	66,899,736	81,166,900
Гэрээний өр төлбөр	24	1,457,762	1,245,531
Орлогын албан татварын өглөг		2,690,628	41,197
Нийт богино хугацаат өр төлбөр		116,242,644	116,172,882
НИЙТ ӨР ТӨЛБӨР		211,142,643	207,763,767
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		313,931,452	193,495,085

Хуудас 5-53 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024	2023
Борлуулалтын орлого	25	598,378,660	390,496,597
Борлуулалтын өртөг	26	(518,272,786)	(393,362,620)
Нийт ашиг/(алдагдал)		80,105,874	(2,866,023)
Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал	27	(34,803,106)	(17,130,606)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	16	(566,913)	(37,447)
Бусад олз, цэвэр	28	21,864,014	3,054,660
Бусад орлого		628,384	17,070
Үйл ажиллагааны ашиг/(алдагдал)		67,228,253	(16,962,346)
Санхүүгийн зардал	29	(19,438,179)	(17,506,483)
Санхүүгийн орлого	30	2,562,377	1,136,615
Орлогын албан татварын өмнөх ашиг/(алдагдал)		50,352,451	(33,332,214)
Орлогын албан татварын (зардал)/өгөөж	31	(2,949,957)	625,911
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ/(АЛДАГДАЛ)		47,402,494	(32,706,303)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АШИГ/(АЛДАГДАЛ)		47,402,494	(32,706,303)
Үүнээс:			
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох		46,598,361	(32,706,303)
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	34	804,133	-
		47,402,494	(32,706,303)
Группийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг/(алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	32	42	(40)

Хуудас 5-53 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Премиум Нэкус ХК
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Бусад өмч	Хуримтлагдсан (алдагдал)/ашиг	Нийт	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт эзэмшигч-дийн өмч
2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	18	81,776,864	13,820,503	318,731	(77,478,477)	18,437,621	-	18,437,621
Тайлант жилийн алдагдал		-	-	-	(32,706,303)	(32,706,303)	-	(32,706,303)
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	18	81,776,864	13,820,503	318,731	(110,184,780)	(14,268,682)	-	(14,268,682)
Тайлант жилийн ашиг		-	-	-	46,598,361	46,598,361	804,133	47,402,494
Гаргасан энгийн хувьцаа		29,648,339	32,020,206	-	-	61,668,545	2,367,049	64,035,594
Хяналтын бус хувь оролцоотой охин компанийн хөрөнгө оруулалт	33, 34	-	-	-	-	-	5,702,196	5,702,196
Ажил гүйлгээний зардал		-	(82,793)	-	-	(82,793)	-	(82,793)
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	18	111,425,203	45,757,916	318,731	(63,586,419)	93,915,431	8,873,378	102,788,809

Хуудас 5-53 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Премиум Нэксус ХК
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

Мянган төгрөгөөр		Тодруулга	2024	2023
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:				
Татварын өмнөх ашиг/(алдагдал)			50,352,451	(33,332,214)
<i>Тохируулгууд:</i>				
Үндсэн хөрөнгийн элэгдэл		9	19,174,982	14,670,795
Үндсэн хөрөнгө борлуулсны (олз)/ гарз, цэвэр		28	(7,492)	27,867
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		9	105,233	161,633
Биет бус хөрөнгийн хорогдуулга		11	1,282,756	1,136,540
Засгийн газрын тусламжийн хорогдуулга		20	375,324	-
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		16	566,913	37,447
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл		10	12,649,118	11,749,379
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз		28	(1,899,749)	(1,722,713)
Гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн (олз)/гарз		28	(45,856)	22,417
Хөрөнгө оруулалт борлуулсны олз		28	-	(342,907)
Тохиролцоот худалдан авалтаас үүссэн олз		28	(19,476,657)	-
Санхүүгийн орлого		30	(2,562,377)	(1,136,615)
Санхүүгийн зардал		29	18,861,121	17,255,606
			79,375,767	8,527,235
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>				
Бараа материал		14	(14,263,111)	3,588,344
Урьдчилгаа		15	(4,521,123)	1,551,938
Дансны ба бусад авлага		16	(1,516,398)	394,541
Бусад татварын өглөг		22	178,483	802,118
Дансны ба бусад өглөг		23	11,919,789	3,195,250
Гэрээний өр төлбөр		24	1,202,403	495,894
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			72,375,810	18,555,320
Зээлийн хүүгийн төлөлт		21	(7,025,530)	(6,805,263)
Орлогын албан татварын төлөлт			(1,014,039)	(39,769)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт		21	(11,916,941)	(10,292,530)
Хүлээн авсан хүү			2,172,877	895,085
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			54,592,177	2,312,843
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Худалдаж авсан үндсэн хөрөнгө		9	(36,332,729)	(34,958,873)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		9	1,169,846	2,387,444
Худалдаж авсан биет бус хөрөнгө		11	(1,821,912)	(245,255)
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		11	-	119,925
Санхүүгийн түрээсийн авлагын төлөлт		10	2,418,645	816,716
Охин компани борлуулсны орлого		28	1,034,381	342,907
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			(33,531,769)	(31,537,136)
Энгийн хувьцаа гаргаж авсан санхүүжилт			2,367,049	30,000,000
Хүлээн авсан зээл		21	63,371,715	31,827,300
Зээлийн эргэн төлөлт		21	(66,526,553)	(23,105,377)
Түрээсийн өр төлбөрийн төлөлт		21	(13,085,709)	(8,797,770)
Зээлийн авлагын эргэн төлөлт			400,000	(2,000,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(13,873,498)	27,924,153
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө			(135,962)	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өөрчлөлт			7,586,910	(1,300,140)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		17	2,980,585	4,280,725
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		17	10,431,533	2,980,585

Хуудас 5-53 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

1 Тайлагнаж буй аж ахуйн нэгжийн танилцуулга

Премиум Нэксус ХК (цаашид “Компани” гэх) болон түүний охин компаниуд (хамтад нь “Групп” гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС Стандартууд”)-ын дагуу бэлтгэгдсэн. 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдөр, Компани нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нэрээ Премиум Нэксус ХК болгон өөрчилсөн.

Компани нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан олон нийтэд нээлттэй хувьцаат компани юм. Компанид 6155804 бүртгэлийн дугаар бүхий 9007001006 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээг 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан бөгөөд Компанийн шууд болон эцсийн толгой компани нь Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Премиум Групп ХХК (“ПГ” гэх) байсан. Компанийн 90.1%-ийг ПГ эзэмшдэг бөгөөд ПГ-ийн эцсийн хяналтыг Монгол Улсын иргэн А.Ганболд болон А.Ганхуяг нар хэрэгжүүлдэг байсан. Компанийн 9.99%-ийг БНСУ-д бүртгэлтэй БиЖиЭф Ритэйл Лимитэд Компани эзэмшдэг байсан.

2021 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын дагуу Компанийн эзэмшлийн бүтэц өөрчлөгдсөн. Премиум Групп ХХК-ийн эзэмшилд байсан Компанийн 90.1% хувьцааг бүгдийг нь 8 хувьцаа эзэмшигчдэд шилжүүлсэн ба тэдгээр хувьцаа эзэмшигчдийн 7 нь мөн Премиум Групп ХХК-ийн хувьцааг эзэмшдэг.

2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Компани Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны 3 дугаар ангилалд бүртгүүлж, 137,960,969 ширхэг шинэ хувьцааг (Компанийн 16.78%) нэгжийг нь 208 төгрөгөөр (нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг) гаргаж, 27,616,599 мянган төгрөгийн (нэрлэсэн үнээс давсан хэсгээс арилжааны зардлыг хассан дүн) хувьцаат капитал татан төвлөрүүлсэн (Тодруулга 18-г харна уу).

2021 онд Компани нь Монголын Хөрөнгийн Биржид амжилттай бүртгүүлж нээлттэй хувьцаат компани болсон. Холбогдох шалгуурыг хангаж, зохих зөвшөөрлийг Монголын Хөрөнгийн Биржээс авснаар Компанийн хувьцаа 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдөр хувьцааны 3 дугаар ангиллаас 2 дугаар ангилал руу шилжсэн.

Дараах хүснэгтэд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн хувьцааны эзэмшлийн хувийг харуулав. Компанийн эцсийн хяналтыг Монгол Улсын иргэд болох ах дүү А.Ганболд болон А.Ганхуяг нар хэрэгжүүлдэг.

№	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь
1	А.Ганхуяг	27.0%
2	А.Ганболд	18.6%
3	Премиум Групп ХХК	17.2%
4	БиЖиЭф Ритэйл Лимитед Компани	8.3%
5	Ц.Баяржаргал	7.9%
6	Бусад хөрөнгө оруулагчид (5%-аас бага)	21.0%
Нийт		100.0%

Компанийн удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагаас бүрддэг. Хувьцаа эзэмшигчид нь Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцох байдлаар Компанийг удирддаг.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

- Стивен Биондо Гари, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус дарга;
- А.Ганхуяг, Гүйцэтгэх захирал;
- А.Ганболд,
- Г.Бат-Эрдэнэ, Санхүү эрхэлсэн захирал;
- Ч.Мөнхчимэг,
- Г.Чинзориг, Гүйцэтгэх захирлын орлогч;
- Б.Бат-Эрдэнэ,
- Ө.Эрдэнэчимэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн;
- В.Ганзориг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн.

1 Тайлагнаж буй аж ахуйн нэгжийн танилцуулга (Үргэлжлэл)

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

- А.Ганхуяг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;
- А.Ганболд,
- Г.Бат-Эрдэнэ,
- З.Уянга,
- Г.Чинзориг, Компанийн гүйцэтгэх захирал;
- Б.Бат-Эрдэнэ,
- Стивен Биондо Гари, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн;
- Ө.Эрдэнэчимэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн;
- В.Ганзориг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн.

Үндсэн үйл ажиллагаа. Групп нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь жижиглэнгийн худалдаа, ая тухтай үйлчилгээ үзүүлэх сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаа, хоолны үйлдвэрлэл болон борлуулалт зэрэг юм. 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Компани нь ая тухтай үйлчилгээ үзүүлэх дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлдэг БНСУ-д байрладаг БиЖиЭф Ритейл Лимитед Компанитай мастер франчайзийн гэрээ байгуулж, дэлгүүрүүдээ Солонгос Улсын бренд болох "CU" болгон шинэчилсэн.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дэлгүүрийн тоо 445 (2023: 374), үүнээс 372 нь Группын эзэмшлийн дэлгүүр (2023: 327), 73 нь дэд франчайз дэлгүүр (2023: 47). 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн ажилчдын тоо 4,677 (2023: 4,308) байсан.

Бүртгэлтэй хаяг болон бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байршил. Группийн бүртгэлтэй хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Их Монголын гудамж, Сакура тауэр, 7 давхарт байрладаг.

Бүртгэлийн болон толилуулгын валют. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь Компани болон түүний охин компаниудын үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно. Тусгайлан зааснаас бусдаар тоон мэдээллийг мянгачилж толилуулсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Группийн Төлөөлөн удирдах зөвлөл батласан.

2 Санхүүгийн тайлагналын зарчим

Тайлагналын нийцэл. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС Стандартуудын дагуу түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн бөгөөд санхүүгийн хэрэглүүрүүдийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь бодит үнэ цэнд суурилсан ба тэдгээрийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр нь ангилсан. Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудыг доор тусган харууллаа. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өөрөөр илэрхийлэгдэхээс бусад тохиолдолд толилуулагдсан бүх тайлант хугацаануудад нэгэн адил тууштай дагаж мөрдөгдөж ирсэн.

СТОУС Стандартуудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зарим чухал тооцооллуудыг ашиглахыг шаарддаг. Мөн Группийн удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг хэрэгжүүлэхдээ үнэлэлт, дүгнэлт хийхийг шаарддаг. Санхүүгийн тайлангуудад мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөө үзүүлэх тооцоолол болон таамаглалууд эсвэл өндөр түвшний үнэлэлт, дүгнэлтийн талаар Тодруулга 4-т тусгасан.

Тасралтгүй байх зарчим. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь удирдлагын зохистой гэж үнэлсэн тасралтгүй байх зарчимд суурилан бэлтгэгдсэн. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн нөхөгдөх дүн болон ангилалтай холбоотой аливаа залруулга ороогүй болно.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

Доор дурдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрөөр заагаагүй бол эдгээр нэгдсэн болон нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгасан бүх тайлант үеүдэд тууштай хэрэгжүүлсэн.

Үндсэн хөрөнгө. Үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэн бууралтын гарзыг хассан дүнгээр толилуулна.

Дараа нь нэмэгдэн гарах зардал, өртгүүдийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг Групп хүртэх магадлалтай бөгөөд тухайн хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд тухайн хөрөнгийн өртөгт тусгах эсвэл тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Урсгал засвар үйлчилгээний өртгийг тухайн гарсан үед нь зардал болгож бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн гол эд ангийг солиход гарсан өртгийг капиталжуулж, хуучин эд ангийг данснаас хасна.

Тайлант хугацааны эцэс бүрд удирдлага нь тухайн хөрөнгийн үнэ цэн буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлж тодорхойлдог. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл удирдлага уг хөрөнгийн нөхөгдөх өртгийг хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь тодорхойлдог. Дансны дүнг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Хэрэв үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэн эсвэл бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орох тохиолдолд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно.

Үндсэн хөрөнгө борлуулсны олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулсан үнийг тухайн үеийн бүртгэлийн дүнтэй харьцуулан тооцож тухайн жилийн орлого үр дүнгийн тайланд бусад олз/(гарз)-д цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Элэгдэл. Бусад үндсэн хөрөнгүүдийн элэгдлийг тооцохдоо хөрөнгийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилна:

	Ашиглалтын хугацаа, жилээр
Барилга	25 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Машин, тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга ба оффисийн хэрэгсэл	2-10 жил
Түрээсийн сайжруулалт	7-10 жил

Группийн тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны эцэст хэрвээ уг хөрөнгө аль хэдийн ашиглагдаж дууссан бол хөрөнгийн борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасаж тооцсон дүнг хөрөнгийн үлдэх өртөг гэдэг. Тайлант хугацаа бүрийн эцэст хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг хянаж үзэх ба шаардлагатай бол залруулдаг.

Ашиглах эрхтэй хөрөнгө. Групп нь дэлгүүрийн үйл ажиллагаанд зориулан талбай түрээслэдэг. Түрээсийн гэрээг ихэвчлэн 2-оос 10 жилийн хугацаанд тогтмол хугацаагаар хийдэг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба өртөг нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийн дүнтэй тэнцүү байна.

Ашиглах эрхтэй хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Хэрвээ Групп түрээсийн хөрөнгийг худалдан авах сонголтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх үндэслэлтэй байгаа бол ашиглах эрхтэй хөрөнгийг ашиглалтын хугацаанд нь элэгдүүлнэ.

Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийг тооцохдоо ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиглан элэгдүүлнэ:

	Ашиглалтын хугацаа, жилээр
Дэлгүүрийн талбай	7-9 жил
Тээврийн хэрэгсэл	1-2 жил
Агуулах	3-6 жил

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт. Группийн үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө болон биет бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэн буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол уг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно.

"Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан шалгадаг. Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн ба хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэн болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Үнэ цэн бууралтын шалгалтын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэн бууралтын алдагдлыг ашиг, алдагдлын тайланд бүртгэдэг. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн хувьд тодорхойлсон үнэ цэн бууралтын алдагдлыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэн бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэн бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл, хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

Бараа материал. Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар нь бүртгэдэг. Барилгын материал, хангамжийн бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагдах (ЭАЭЗ) өртгийн аргаар тооцоолдог. Дахин борлуулах бараа материалын өртгийг жижиглэн худалдаалах барааны аргыг ашиглан тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн нөхцөлд барааг борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасаж тооцно.

Биет бус хөрөнгө. Группийн гүүдвиллээс бусад биет бус хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа нь тодорхой ба түүнд голдуу капиталжуулсан франчайзын хураамж болон компьютерын лицензүүд ордог.

Биет бус хөрөнгийг ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна:

	Ашиглалтын хугацаа жилээр
Франчайзын төлбөр	10 жил
Програм хангамжийн лиценз	5 жил
Газар эзэмших эрх	25 жил

Биет бус хөрөнгүүдийг үлдэх өртөг, ашиглалтын хугацаа болон хорогдуулалтын аргыг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж, шаардлагатай бол залруулдаг.

Хэрэв үнэ цэн буурсан тохиолдолд биет бус хөрөнгийн дансны үнийг ашиглалтын үнэ цэн болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгийн аль их дүн хүртэл бууруулдаг.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр – хэмжилтийн үндсэн нөхцөлүүд. Бодит үнэ цэн гэж хэмжилт хийгдэх тухайн өдөр зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө худалдсан бол хүлээн авах буюу өр төлбөр шилжүүлсэн бол төлөх байсан үнийг хэлнэ. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бол идэвхтэй зах зээл дээрх үнэ байдаг. Идэвхтэй зах зээл гэдэг нь давтамж, тоо хэмжээний хувьд үнийн мэдээллийг тогтмол нийлүүлж чадах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой гүйлгээ гарч байдаг зах зээлийг хэлдэг.

Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хөрөнгө буюу өр төлбөр тус бүрийн жишиг үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хэрэглүүрүүдийн тоо хэмжээгээр хэмждэг. Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь Группийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байх мөн нэг арилжаагаар борлуулах захиалгын тоо хэмжээ зэрэг нь жишиг үнэд нөлөөлөх тохиолдол байдаг.

Зах зээлийн үнийн талаарх хөндлөнгийн мэдээлэл олдохгүй байх зарим санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд тэдгээрийн бодит үнэ цэнийг хөрөнгө оруулагч талын санхүүгийн мэдээлэлд үндэслэн дискаунтлагдсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцно. Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн шатлалын дагуу дараах байдлаар шинжилдэг. Үүнд: (i) Нэгдүгээр түвшин нь ижил хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэнд (залруулагдаагүй) үндэслэн хийсэн хэмжилт, (ii) Хоёрдугаар түвшний хэмжилт нь тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс тооцон гаргасан) ажиглагдахуйц бүхий л материаллаг хэмжээний орц мэдээллийг ажиглах үнэлгээний арга, техникүүд (iii) Гуравдугаар түвшний хэмжилт нь зах зээлээс ажиглагдахуйц бус тоо мэдээнд үндэслэн хийсэн үнэлгээнүүд (хэмжилт нь чухал үл ажиглагдахуйц орц мэдээллийг шаарддаг) орно.

Ажил гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээ хийгдээгүй тохиолдолд гарахгүй байх байсан зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч (борлуулалтын агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах байгууллага, хөрөнгийн зах зээлийн байгууллагад төлсөн төлбөр, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэлийн зардал эсвэл хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, захиргааны дотоод зардал буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг (ХӨ) гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасч, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайланд хамаарах хэсэгт дансны үнээр тусгасан.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид бүртгэлийн дүнгээс тооцогдох хүүгийн хувь (үр ашигт хүүгийн хувь)-ийг тогтмол байлгахаар хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн эрсдэлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтчилж, санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн нийт дүнг гаргаж авах хүүгийн хувь болно.

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрүүдийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөгч хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй ба бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцооллод гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах ба тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авахад эсвэл шинээр олгоход үнэ цэнийн бууралт хийгдсэн хөрөнгө ("POCI") -ийг анх хүлээн зөвшөөрөх үед үр ашигт хүүгийн түвшинг зээлийн эрсдэлд тохируулан бүртгэнэ. Үүнд: анх хүлээн зөвшөөрөхдөө гэрээний төлбөрийн оронд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн тооцоолно.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэн бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анхлан гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Анхлан хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэн нь гүйлгээний дүнгээр хамгийн сайн нотлогдоно. Анхлан хүлээн зөвшөөрөх үед үүсэх олз эсвэл гарз нь зах зээлийн үнэ болон гүйлгээний дүнгийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийн идэвхтэй зах зээл дээрх сүүлийн үеийн арилжааны мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн идэвхтэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэх болно. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа ХБЭА-ын хасагдуулгыг хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрдөг ба өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж гарсан үр дүн нь шууд бүртгэлийн гарз болдог.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтоогдсон ("хэвийн" борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Групп тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Групп нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн төрөл. Групп нь санхүүгийн хөрөнгийг хэмжилтээр нь дараах төрлүүдэд ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэн ("ААБҮЦ"), Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэн ("БДОБҮЦ") болон Хорогдуулсан өртөг ("ХӨ"). Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) холбогдох хөрөнгүүдийн багцыг удирдах Группийн бизнес загвар болон (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес загвар. Бизнес загвар нь Групп санхүүгийн хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл Группийн зорилго нь (i) зөвхөн тухайн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших) эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба худалдах зорилгоор эзэмших) бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль нь ч биш тохиолдол бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Группийн хийж буй үйл ажиллагаанд хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн бүлэг хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Бизнес загварыг тодорхойлоход Группийн авч үзсэн хүчин зүйлүүдэд багцын бүрэлдэхүүн болон зорилго, холбогдох хөрөнгүүдийн мөнгөн урсгал хэрхэн цуглуулагдаж байсан талаарх өнгөрсөн үеийн туршлагауд, эрсдэлийг хэрхэн удирдаж үнэлж байсан, хөрөнгүүдийн гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байсан болон менежерүүдэд хэрхэн нөхөн төлбөр олгогдож байсан зэргийг авч үздэг.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог. Бизнес загвар нь хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулж, хөрөнгийг эзэмших эсвэл хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрдэж буй ("ЗҮХТ") эсэхэд Групп үнэлгээ өгдөг. Гэрээт мөнгөн урсгал нь ЗҮХТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ.

Энэ үнэлгээг хийхдээ гэрээт мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэн болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. ЗҮХТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал. Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлант үеийн эхнээс хэрэгжинэ. Групп нь тайлант болон харьцуулсан өмнөх тайлант хугацааны туршид бизнесийн загвараа өөрчлөөгүй бөгөөд дахин ангилал хийгээгүй.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулга. Групп нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүртэй холбоотой хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ирээдүйд чиглэсэн мэдээлэлд үндэслэн үнэлдэг. Групп нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ("ХБЭА") хэмжиж, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын цэвэр гарзыг тайлант хугацаа бүрд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дундаж дүн; (ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэн; болон (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээлэлд үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өрийн хэрэглүүр, дансны ба бусад авлага, олгосон зээлийн авлага болон гэрээний хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд ХБЭА-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тусгадаг.

Групп дансны авлага болон түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын хувьд хугацааны турш дахь хүлээгдэж буй алдагдлын хасагдуулгыг ашиглан ХБЭА-ыг хэмжихдээ хялбаршуулсан аргагүйг ашигладаг. Бусад санхүүгийн хөрөнгийн хувьд Групп нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа зээлийн чанарын өөрчлөлтөнд үндэслэсэн үнэ цэнийн бууралтанд "3 шатлал" бүхий дараах загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр ямар нэг үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хэрэглүүр нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын санхүүгийн хэрэглүүрийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв Групп анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн ("ЗЭМӨ") гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д ангилах бөгөөд ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (ашиглалтын хугацааны ХБЭА). Тодруулга 36-д Групп нь зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн хэрхэн тодорхойлдог талаар тайлбарласан. Хэрэв Групп санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэн буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэх ба ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Группийн зээлийн үнэ цэн буурсан хөрөнгийн тодорхойлолт болон дефолтын тодорхойлолтыг

Тодруулга 36-д тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дахь ХБЭА-тай ижил хэмжигдэнэ. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээлэл, таамаглал болон тооцооллын аргуудыг мөн Групп ХБЭА-ын загваруудын ирээдүйн мэдээллийг хэрхэн нэгтгэх талаарх тайлбарыг Тодруулга 36-аас үзнэ үү.

Санхүүгийн хөрөнгө - данснаас хасах. Групп санхүүгийн хөрөнгийг нэхэмжлэх ажилд бүх хүчин чармайлтаа өгч нэхэмжлэх үндэслэл байхгүй гэж дүгнэсэн тохиолдолд бүхэлд нь буюу зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь бүртгэлээс хасах үйл явдлыг илэрхийлнэ. Групп нь гэрээний дагуу төлөгдөх дүнг нэхэмжлэхийг хүсэж байгаа боловч төлөгдөх боломжийн таамаглал байхгүй байгаа тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн хөрөнгийг данснаас хасах боломжтой.

Санхүүгийн хөрөнгө – үл хүлээн зөвшөөрөх. Групп нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) санхүүгийн хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй.

Холбогдох тал хөрөнгийн борлуулалтанд нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө - өөрчлөлт. Группд санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцох тохиолдол гардаг. Групп нь гэрээт мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн (жишээ нь, ашгийн хувь эсвэл өмчид суурилсан өгөөж) эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, валютын ханшийн өөрчлөлт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож Групп анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн Групп шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Групп нь хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөнд эрсдэл болон өгөөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөхгүй. Групп нь анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээт мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал. Санхүүгийн өр төлбөрүүдийг дараахаас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгөөр хэмжиж ангилна. Үүнд (i) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцэлээс үүссэн санхүүгийн өр төлбөр болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн бусад санхүүгийн өр төлбөр, (ii) зээлийн амлалтууд хамаарна.

Санхүүгийн өр төлбөр - үл хүлээн зөвшөөрөх. Санхүүгийн өр төлбөр хүчингүй болох үед (өөрөөр хэлбэл гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэж дууссан, цуцлагдсан эсвэл хугацаа дууссан) бүртгэлээс хасагдана.

Групп болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл бүхий өрийн хэрэглүүр болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг данснаас хасаж, шинэ санхүүгийн өр төлбөр бүртгэх үндэслэл болно.

Аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан шинэ нөхцөлөөрх мөнгөн гүйлгээний хорогдуулсан өнөөгийн үнэ цэн нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн гүйлгээний хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр хүчингүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн олз, гарзаар бүртгэдэг. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамжийн зардлын дүнгээр өр төлбөрийн дансны үнийг нэмэгдүүлэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацааны туршид хорогдуулж тооцно.

Дансны үнийн өөрчлөлтийн эдийн засгийн шинж чанар нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд барагдуулаагүй байгаа өр төлбөрийн өөрчлөлтийг хуримтлуулан тооцох аргыг ашиглан тооцоолоход гарсан өөрчлөлт гэж тооцон бүртгэдэг. Үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Энэхүү хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох үйл явдлын болзошгүй төлбөр биш байх, (б) дараах тохиолдол бүрийг хуульд заагдсанаар шийдэх буюу (i) бизнесийн хэвийн үйл ажиллагаа, (ii) төлбөр төлөгдөхгүй болох (iii) төлбөрийн чадваргүй болж дампуурсан үед бий болдог.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах хадгаламжийн мөнгө, 3 сар болон түүнээс богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Учир нь: (i) тэдгээр нь гэрээний мөнгөн урсгалаас цуглуулагдан эзэмшиж байгаа болон тэдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮХТ-ийг харуулсан байдаг болон (ii) тэдгээр нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй байдаг.

Зарим улсын батлан даалтын хууль тогтоомж гэх мэт зөвхөн хуулиар баталгаажуулсан онцлог шинжүүд нь хууль тогтоомж өөрчлөгдсөн ч гэсэн уг онцлог шинж чанарыг хэрэглэж болох тул гэрээний нөхцөлд оруулахаас гадна ЗХҮТ-ийн тестэд нөлөөлөхгүй.

Дансны ба бусад авлага. Дансны ба бусад авлагуудыг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба цаашдаа үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Дансны ба бусад өглөг. Дансны өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан бүртгэх ба анх бодит үнэ цэнээр, цаашид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрдөг.

Зээл. Зээлийг анх гүйлгээний зардлыг хассан дүнгээр буюу бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба цаашид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Зээлийн өртөг. Групп шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлнэ.

Шалгуурт нийцсэн хөрөнгийг олж бэлтгэх зориулалтаар тусгайлан авсан зээлийн санхүүжилттэй холбогдуулан Групп тухайн хөрөнгийн дүнд капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тайлант үеийн туршид гарсан зээлийн бодит зардлаас тухайн зээлийн түр зуурын хөрөнгө оруулалтаас олсон аливаа орлогыг хасч тодорхойлно. Групп бусад зээлийн өртгийг нэн даруй зардал гэж хүлээн зөвшөөрнө. Групп ерөнхий зориулалтаар авсан бөгөөд бэлтгэл ажил шаардагдах хөрөнгийг олж бэлтгэх зориулалтаар ашиглаж байгаа зээлийн санхүүжилтийн хүрээнд, капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тухайн хөрөнгийн зарлагын капиталжуулалтын түвшинг ашиглаж тодорхойлох ёстой. Капиталжуулалтын түвшин нь шалгуурт нийцсэн хөрөнгөд зориулж Группийн тусгайлан авсан зээлээс бусад тайлант үеийн туршид төлөгдөөгүй зээлд тохирох зээлийн өртгийн жинлэсэн дундаж болно.

Засгийн газрын тусламж. Засгийн газрын тусламжийг хүлээн авах нь тодорхой болсон ба дагалдах бүх нөхцөлүүдэд нийцнэ гэж үзэж байгаа үед хүлээн зөвшөөрнө. Засгийн газрын тусламж нь зардлын зүйлтэй холбогдож байгаа үед засгийн газрын тусламжийг нөхөгдөх зардлуудтай уялдуулан шаардагдах хугацааны туршид орлогоор хүлээн зөвшөөрнө.

Засгийн газрын тусламж нь хөрөнгөтэй холбогдож байгаа үед үүнийг холбогдох хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид тэнцүү хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрнө. Групп нь мөнгөн бус хөрөнгийн тусламж хүлээн авсан тохиолдолд, хөрөнгө болон тусламжийг нэрлэсэн үнээр бүртгэж хөрөнгийн ашиглалтын хугацаанд суурь хөрөнгийн өгөөжийг ашиглах хугацаанд ижил дүнгээр ашиг, алдагдалд бүртгэнэ.

Групп нь засгийн газрын зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэй эсвэл хүүгүй зээлийг хүлээн авсан тохиолдолд засгийн газрын тусламжийг анх бүртгэх дүнг үр ашигт хүүний аргыг ашиглан тодорхойлно. Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэй эсвэл хүүгүй зээлийн өгөөж нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлсон зээлийн анхны дансны үнэ ба хүлээн авсан мөнгөн дүнгийн зөрүү байх ба ашиг алдагдлын тайланд орно.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Санхүүгийн түрээсийн авлага. Групп дэд-түрээсийн хэлцэлд түрээслүүлэгчээр оролцож, түрээслэгчид Группийн өмчлөлтэй дагалдах бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн тохиолдолд түрээслүүлсэн хөрөнгийг түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний дүнгээр санхүүгийн түрээсийн авлага гэж тайлагнана. Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтыг түрээсийн эхлэх өдрөөс хэмжихэд дараах түрээсийн төлбөр орно:

- тогтмол төлбөрүүд (мөн чанарын хувьд тогтмол төлбөрүүд мөн орно), хасах нь аливаа түрээсийн урамшууллын өглөг,
- баталгаат үлдэх өртгийн дагуу Группийн авахаар тооцоолж буй дүн,
- түрээсийн гэрээнд түрээсийн хугацааг цуцлах эрхтэй үед түрээсийн гэрээг цуцлахад үүсэх торгуулийн төлбөр,
- санхүүгийн түрээсийн авлагыг түрээсийн хугацаа эхлэхэд анхлан хүлээн зөвшөөрөх ба түрээсийн гэрээнд түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын дүнг тооцохоор тусгасан хорогдуулалтын хүүг ашигладаг.
- Нийт авлага ба өнөөгийн үнэ цэнийн зөрүү нь хойшлогдсон санхүүгийн орлогыг илэрхийлнэ. Энэхүү орлогыг түрээсийн хугацааны туршид цэвэр хөрөнгө оруулалтын аргыг ашиглан хүлээн зөвшөөрөх (татварын өмнөх) ба энэ нь өгөөжийн тогтмол хувийг илэрхийлдэг. Түрээсийн хэлцэл хийх, тохиролцохтой шууд холбоотой нэмэгдэл зардлыг санхүүгийн түрээсийн авлагын анхны хэмжилтэд багтааж, түрээсийн хугацаанд хүлээн зөвшөөрсөн орлогын хэмжээг бууруулна. Дэд түрээсийн санхүүгийн орлогыг тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд санхүүгийн орлогоор бүртгэнэ.

Эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцоходоо хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хялбаршуулсан аргыг ашигладаг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг дансны авлагынхтай адил аргаар тооцдог. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хасагдуулгын дансаар дамжуулан авлагын дансны цэвэр дүнг бууруулж бүртгэх ба санхүүгийн түрээсэд хамааруулсан хүүгийн хэмжээгээр дискаунтлагдсан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээ нь түрээстэй холбоотой хөрөнгийг олж авах, борлуулснаас үүсэх мөнгөн урсгалыг илэрхийлдэг.

Түрээсийн өр төлбөр. Түрээсийн өр төлбөрийг анхлах хэмжихдээ өнөөгийн үнэ цэнд суурилдаг. Түрээсийг өр төлбөр нь дараах түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг агуулдаг:

- тогтмол төлбөрүүд (мөн чанарын хувьд тогтмол төлбөрүүд мөн орно), хасах нь аливаа түрээсийн урамшууллын авлага,
- эхлэлийн өдөр индекс буюу хувь хэмжээг ашигласнаар анх хэмжсэн, индекс буюу хувь хэмжээнээс хамаардаг, түрээсийн хувьсах төлбөр,
- баталгаат үлдэх өртгийн дагуу Группийн төлөхөөр тооцоолж буй дүн;
- худалдан авах сонголтоо Групп хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх, болон
- Групп нь түрээсийн гэрээг цуцлах эрхтэй үед түрээсийн гэрээ цуцалсны торгууль.

Групп нь түрээс тус бүрийн хэрэгжих хугацааг тодорхойлохдоо, түүний эдийн засгийн үр өгөөжийг харгалзан үзэж тодорхойлдог. Эдийн засгийн үр өгөөж гэдэгт томоохон хэмжээний торгууль эсвэл алдагдлыг хамруулан үздэг. Групп гэрээний өдөр тухайн түрээсийн үргэлжлэх хугацааг түрээсийн гэрээний хугацаанаас уртаар тогтоож болох ба энэ хугацаа нь гэрээ цуцалснаар үүсэх торгууль эсвэл алдагдлын хэмжээ бага болох хүртэл байна.

Түрээсийн төлбөрүүдийг нуугдмал хүүгийн түвшнээр хорогдуулах ба хэрвээ тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшинг ашиглана. Энэ нь Групп эдийн засгийн ижил төстэй нөхцөл байдалд ашиглах эрхтэй хөрөнгөтэй ижил төстэй өөр хөрөнгийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг ижил төстэй барьцаа болон нөхцөлөөр зээлэх үед төлөх зээлийн хүүгийн түвшинг хэлнэ.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшинг тодорхойлохын тулд Групп:

- боломжтой бол гуравдагч талын санхүүжилт хүлээн авснаас хойш гарсан өөрчлөлтийг тусгаж тохируулсан эхлэл болгон хувь түрээслэгч хүлээн авсан санхүүжилтийг ашиглана;
- зээлийн эрсдэлд тохируулсан, эрсдэлгүй хүүгийн түвшний аргыг ашиглах;
- түрээсийн талаарх зарим зохицуулалт хийх, ж.нь. хугацаа, улс орон, валют, барьцаа хөрөнгө гэх мэт.

Групп ирээдүйд түрээсийн төлбөрийг индекс, хувь хэмжээнд үндэслэн нэмэгдүүлэх боломжтой тул түрээсийн өр төлбөрт хүчин төгөлдөр болох хүртэл тооцоогүй болно. Индекс эсвэл хувь хэмжээнд суурилсан түрээсийн төлбөрт хийсэн өөрчлөлтүүд нь түрээсийн төлбөрийг дахин ашиглах, ашиглах эрхтэй хөрөнгөөр тохируулна.

Түрээсийн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн зардлын хооронд хуваарилдаг. Санхүүгийн зардал нь түрээсийн хугацааны туршид орлого үр дүнгийн тайланд тусгагдах бөгөөд тайлант хугацаа бүрт үе тутмын тогтмол хүүгийн зардлаар түрээсийн өр төлбөрийн үлдэгдэлд илэрхийлэгдэнэ.

Түрээсийн богино хугацаатай болон бага өртөг бүхий бүх төрлийн хөрөнгийн түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хуваарилан орлого үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Түрээсийн хугацаа нь 12 сар ба түүнээс бага бол богино хугацааны түрээс байдаг. Бага өртөгтэй хөрөнгөд арван таван сая төгрөг ба түүнээс доош үнэтэй тоног төхөөрөмжүүд багтдаг.

Орлогын албан татвар. Орлогын албан татвар нь нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлант хугацааны эцсийн байдлаар батлагдсан эсвэл үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжийн хүрээнд хуримтлуулан бүртгэгдсэн байна. Орлогын албан татварын зардал нь тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны албан татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдуулах ашиг эсвэл алдагдлаас бодогдсон татварын байгууллагад төлөх эсвэл буцаан авах дүн байна. нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг холбогдох татварын тайланг тушаахаас өмнө баталгаажуулсан тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилсан тооцоололд үндэслэж тооцдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх үед хойшлогдсон орлогын албан татварыг тооцохдоо тайлан тэнцлийн өглөгийн аргыг ашиглах ба хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх бүртгэлийн дүн болон татварын суурийн хоорондын түр зөрүүг тайлант хугацаанд тооцож бүртгэдэг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүнд хойшлогдсон татвар бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг. Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасч ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө.

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ). Борлуулалтад ногдуулах нэмэгдсэн өртгийн татварыг (а) харилцагчаас авлага хүлээн авсан өдөр (б) харилцагчид бараа үйлчилгээ үзүүлсэн өдөр хоёрын аль эртээр нь тооцогдож татварын албанд борлуулалттай холбоотой өглөг үүсгэнэ. НӨАТ-ын худалдан авалт нь ерөнхийдөө НӨАТ-ын нэхэмжлэлийг хүлээн авах үед НӨАТ-ын борлуулалтаас буцаан хасагддаг. Татварын байгууллага НӨАТ-ыг цэвэр буюу хасагдуулсан дүнгээр төлөхийг зөвшөөрдөг. Борлуулалт, худалдан авалттай холбоотой НӨАТ нь санхүүгийн байдлын тайланд нийт дүнгээр хүлээн зөвшөөрөгдөх буюу НӨАТ-ын авлага буюу өглөгийн дүнгээр санхүүгийн байдлын тайлангийн өглөг эсвэл авлагын хэсэгт тусгагддаг.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Хэрэв авлагын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалд зориулж нөөц байгуулсан бол үнэ цэнийн бууралтын гарз нь НӨАТ-ыг оролцуулсан нийт дүнгээр тусгагддаг. НӨАТ-ын тухай хуулийн 14.1.5-т заасны дагуу тоног төхөөрөмж угсрах болон худалдан авахад төлсөн НӨАТ-ыг угсрах болон худалдан авах өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд төлсөн НӨАТ-аас суутган тооцож, хувь тэнцүүлэн хорогдуулж хойшлуулна. Тайлант үеэс хойш арван хоёр сарын дотор ашиглах буюу суутгахаар хүлээгдэж буй хойшлогдсон НӨАТ-ын авлагыг эргэлтийн хөрөнгөд тусгаж, тайлант хугацаанаас хойш арван хоёр сараас дээш хугацаагаар ашиглах буюу суутгахаар тооцсон дүнг бусад эргэлтийн бус хөрөнгөд тус тус тусган бүртгэнэ.

Урьдчилж төлсөн төлбөр. Урьдчилж төлсөн төлбөрийг өртгөөс үнэ цэн бууралтын зардлыг хассан дүнгээр бүртгэнэ. Урьдчилгаа төлбөр хийгдсэн бараа үйлчилгээг нэг жилээс хойш хүлээн авахаар хүлээгдэж буй тохиолдолд эсвэл урьдчилгаа төлбөр хийгдсэн хөрөнгө нь өөрөө анх эргэлтийн бус гэж ангилагдсан тохиолдолд уг урьдчилж төлсөн төлбөрийг эргэлтийн бус гэж ангилна. Групп холбогдох хөрөнгийг хянах эрх олж авсан бөгөөд уг хөрөнгө нь Группд эдийн засгийн үр өгөөж ирээдүйд өгөх магадлалтай болсон үед хөрөнгө худалдан авахаар хийгдсэн урьдчилж төлсөн төлбөрийн дүнг хөрөнгийн дансны үнэнд шилжүүлэн бүртгэнэ. Бусад урьдчилж төлсөн төлбөрийг холбогдох урьдчилгаа төлбөр хийгдсэн бараа, үйлчилгээг хүлээн авсан үед ашиг, алдагдлаас хасаж бүртгэнэ. Урьдчилж төлсөн төлбөртэй холбоотой хөрөнгө, бараа, үйлчилгээ нийлүүлэгдэхгүй байх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд урьдчилж төлсөн төлбөрийн дүнг зохих хэмжээгээр бууруулж холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Хувьцаат капитал. Энгийн хувьцааг эзэмшигчдийн өмчид ангилан бүртгэдэг. Шинээр энгийн хувьцаа гаргахтай шууд холбогдон гарсан нэмэгдэл зардлыг өөрийн хөрөнгийн хэсгийн энгийн хувьцааны сөрөг тохируулах данс байдлаар, татварын дараах цэвэр дүнгээр тусгадаг. Гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс хүлээн авсан төлбөр болох бодит үнэ цэнээс илүү гарсан дүнг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэдэг.

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд. Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Групп холбоотой талуудтай гүйлгээ хийдэг. Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Групп холбоотой талуудтай гүйлгээ хийдэг. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр нь анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэхийг шаарддаг. Энэхүү ажил гүйлгээг зах зээлийн эсвэл зах зээлийн бус (өөрөөр хэлбэл энэхүү ажил гүйлгээтэй холбоотой идэвхтэй зах зээл байхгүй) хүүтэй уялдсан эсэхийг тодорхойлоход үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээнд өөр бусад харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ижил төрлийн ажил гүйлгээний үнийн дүн болон үр ашигт хүүгийн шинжилгээг үндэс болгодог. Холбоотой талуудын дансдын үлдэгдэлтэй холбоотой нөхцөлүүдийг Тодруулга 8-аас харна уу.

Холбоотой талууд. Групп болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэж үзнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Групптай холбоотой гэж үзнэ:

- Группийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Группд мэдэгдэхүйц нөлөөлөлтэй; эсвэл
- Группийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Групптай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Групп нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд харилцан холбоотой гэсэн үг юм;
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан Группын нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
- Хоёр компани хоёулаа гуравдагч талын хамтарсан хяналттай компани бол;
Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Аж ахуйн нэгж нь Группын эсвэл Групптай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоорх ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан доор байх; Группийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой Группийн удирдах ажилтан байх.

Нөөц. Групп өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн үүрэг хариуцлага (хуулийн эсвэл ёс зүйн) хүлээсэн, энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгал бий болох магадлалтай ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

Нөөцийн хамгийн сайн тооцооллыг хийхийн тулд үйл явдал, нөхцөл байдлын хүрээлэн байгаа эрсдэл, тодорхойгүй байдал зэргийг харгалзаж үзэх ёстой. Мөнгөний цаг хугацааны үнэ цэн нь материаллаг нөлөөтэй бол нөөцийн дүн нь ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн байдаг.

Нөөцийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь өөр нэг талаас нөхөн авахаар хүлээгдэж байгаа үед, хэрэв Групп үүрэг хариуцлагынхаа дагуу төлбөрийг барагдуулсан үед нөхөн олговор хүлээн авах нь тодорхой байх нөхцөлд л зөвхөн нөхөн олговрыг хүлээн зөвшөөрөх ёстой. Нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж үздэг.

Нөөцийн дүнг тайлангийн хугацааны эцэст давтан шалгаж, тайлангийн үеийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд тохируулж байдаг. Хэрэв үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгал нь магадлал багатай бол нөөцийн дүнг буцаадаг. Нөөцийг зөвхөн анх нөөц гэж хүлээн зөвшөөрсөн зарлагад ашиглана.

Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр. Болзошгүй хөрөнгө болон өр төлбөрүүд нь бодитой тохиолдох эсэх нь тухайн байгууллагийн бүрэн хяналтаас хамааралгүйгээр ирээдүйн нэг ба түүнээс дээш үйл явдлаас хамаарч тайлагнадаг. Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал маш бага бол болзошгүй өр төлбөр гэж үзэхгүй.

Орлого хүлээн зөвшөөрөлт. Борлуулалтын орлого нь Группийн ердийн үйл ажиллагаанаас үүсдэг. Орлогыг ажил гүйлгээний үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Ажил гүйлгээний үнэ гэдэг нь үйлчлүүлэгчид гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээгээ шилжүүлснийхээ оронд авах эрхтэй болсон төлбөрийн дүн юм. Үүнд гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн орохгүй. Орлогыг борлуулалтын цэвэр дүнгээр буюу хөнгөлөлт, буцаалт болон нэмэгдсэн өртгийн албан татвар, экспортын татвар, онцгой албан татвар, адилтгах бусад заавал төлөх төлбөрийг хасч цэвэр дүнгээр нь хүлээн зөвшөөрдөг.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Бараа борлуулсны орлого.

(а) Групп жижиглэнгийн сүлжээ дэлгүүр ажиллуулдаг. Групп борлуулсан барааны орлогыг үйлчлүүлэгчдэд бүтээгдэхүүн борлуулах үед хүлээн зөвшөөрдөг.

(б) Үйлчлүүлэгч бараа худалдаж авахдаа төлбөрийг бэлнээр төлдөг. Группийн бодлогын дагуу эцсийн хэрэглэгчдэд 24 цагийн дотор худалдан авсан бараагаа буцаах эрх өгдөг. Түүхэн туршлагаас харахад буцаагдсан барааны тоо материаллаг бус байдаг бөгөөд одоогоор хүлээн зөвшөөрсөн борлуулалтад томоохон хэмжээний буцаалт хийгдэх магадлал бага байна.

(в) Групп жижиглэнгийн худалдан авагчдадаа худалдан авалтаас нь урамшууллын оноо олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд худалдан авагч нар уг оноог ирээдүйн худалдан авалтандаа ашиглах боломжтой. Онооны дагуу худалдан авагчдад олгогддог материаллаг эрх нь гэрээний үндсэнд олгогддог. Тиймээс, худалдан авагчдад оноо олгох амлалт нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг болдог. Борлуулалтын үнийг бүтээгдэхүүн болон оноонд тус тусад нь харьцангуй тусдаа борлуулалтын үнэд суурилан хуваарилдаг. Нэгж онооны тусдаа борлуулалтын үнэ нь нэг төгрөг. Борлуулсан бүтээгдэхүүний тусдаа борлуулалтын үнэ нь жижиглэнгийн үнэтэй тэнцүү. Борлуулалтын үнээс оноонд хуваарилсан дүнгээр урьдчилж олсон орлого бүртгэдэг ба худалдан авагч оноогоо ашиглах үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

(г) Групп нь заримдаа худалдан авагчдад урамшууллын хөтөлбөр санал болгодог (жишээ нь гурвыг авбал нэг үнэгүй). Энэ нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг гэж тооцогдох материаллаг эрх юм. Борлуулалтын үнээс харьцангуй тусдаа борлуулалтын үнэд суурилан материаллаг эрхэд хуваарилагддаг. Бүтээгдэхүүнийг үнэгүй авах эрх сүүлийн худалдан авалт дээр 100% хэрэгжих ба тухайн үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

(д) Хямдралтай борлуулалтаас олсон орлогын хямдруулалтын дүнг хассан цэвэр борлуулалтын үнэнд үндэслэн хүлээн зөвшөөрнө.

Дэд франчайзын борлуулалтын орлого. Барааны хяналтыг шилжүүлэх үед буюу барааг дэд франчайз дэлгүүрт хүргэж өгөх үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Дэд франчайз дэлгүүрүүд барааг захиран зарцуулан бүрэн эрхтэй бөгөөд дэд франчайзын барааг хүлээж авахад нөлөөлөхүйц биелэгдээгүй үүрэг байхгүй. Барааг тухайн байршилд аваачсан, хуучирч муудах болон алдагдах эрсдэл дэд франчайзад шилжсэн, дэд франчайз нь барааг гэрээний дагуу хүлээж авсан эсхүл хүлээн авснаа илэрхийлэх хугацаа өнгөрсөн эсвэл Группд бүх шаардлага хангагдсан гэж үзэх бодит баримт байгаа тохиолдолд хүргэлт хийгдсэн гэж үзнэ.

Брэнд нэр ашигласны эрхийн шимтгэл. Групп өөрийн брэнд нэрийг ашиглан дэлгүүрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрхийг дэд франчайзингд олгох ба төлбөрийг урьдчилан хүлээж авдаг. Дэд франчайзын эрх нь тусдаа гүйцэтгэлийн үүрэг болох бөгөөд хугацааны туршид хэрэгжинэ. Дэд франчайзаас хүлээн авсан урьдчилгаа төлбөрийг франчайзын гэрээний хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн хугацаанд хуваарилах гүйлгээний дүнгийн хувьд урьдчилж олсон орлого хүлээн зөвшөөрдөг.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Бусад үйлчилгээний орлого. Групп нь тогтмол болон хувьсах үнэ бүхий гэрээний дагуу үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг. Тогтмол үнэтэй гэрээний хувьд тайлант хугацааны эцэс хүртэл бодитоор үзүүлсэн үйлчилгээнд үндэслэн орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гэрээнд нэгээс олон гүйцэтгэлийн үүрэг байгаа тохиолдолд тусдаа борлуулалтын үнэд үндэслэн борлуулалтын үнийг гүйцэтгэлийн үүрэг тус бүрд хуваарилан тооцдог. Тусдаа борлуулалтын үнийг шууд тодорхойлох боломжгүй үед өртөг дээр ахиуц ашгийг нэмэх аргаар тооцоолно.

Тогтмол үнэтэй гэрээний хувьд, харилцагчид гэрээндээ тулгуурлан тогтмол дүнг төлдөг.

Хэрэв гэрээнд хувьсах нөхцөлийг багтаасан бол орлогыг буцаалт хийгдэхгүй байх өндөр магадлалтай хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

Хүүгийн орлого. Хүүгийн орлогыг ААБҮЦ-ээр бүртгэгдсэнээс бусад бүх өрийн хэрэглүүр бүрийн хувьд аккруэл суурьт үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талууд хоорондын гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж болон бусад бүх нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого болгон бүртгэдэг. Нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцоолсон ААБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хүүгийн орлогыг орлого, үр дүнгийн тайланд "санхүүгийн орлого"-д тусгадаг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид Группийн санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно.

Ажилчдын зардал ба тэтгэмжүүд. Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Группийн ажиллагсад холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралт гэх мэт цалинтай богино хугацааны хуримтлагдан тооцогдох чөлөөг ажиллагсад ирээдүйд цалинтай чөлөө авах эрх олж авах үйлчилгээг үзүүлсэн үед, цалинтай богино хугацаат хуримтлагдахгүй чөлөөг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авах) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого үр дүнгийн тайланд зардлаар бүртгэдэг. Групп нь хуульд зааснаас өөр тэтгэвэр болон бусад тэтгэмжийн хөтөлбөрт төлбөр төлөх ямар нэгэн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

Сегментийн тайлагнал. Үйл ажиллагааны сегментийн тайланг Группийн ҮААШГ-чид ашигладаг дотоод тайлагналтай нийцүүлэн гаргадаг. Группийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагыг ҮААШГ гэж тодорхойлсон. ҮААШГ нь байгууллагын нөөцийг хуваарилж, үйл ажиллагааны сегментийн гүйцэтгэлийг үнэлэх үүрэгтэй. Тайлагнах сегментүүдийн орлого, үр дүн эсвэл хөрөнгийн дүн нь нийт сегментүүдийн нийлбэр дүнгийн 10 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлдэг сегментийг тусад нь тайлагнадаг.

Бизнесийн нэгдэл. Бизнесийн нэгдлийг бүртгэхэд хувьцаа эсвэл бусад хөрөнгө худалдан авснаас үл хамааран худалдан авалтыг аргыг ашиглана. Худалдан авалтын аргачлалын дагуу охин компанийг худалдан авахад шилжүүлсэн төлбөр нь дараах зүйлсийг агуулна. Үүнд:

- Шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэн;
- Худалдан авч буй бизнесийн өмнөх эзэмшигчдийн өр төлбөр;
- Группийн гаргасан хувьцаа;
- Болзошгүй заалтын үр дүнд бий болсон аливаа хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн;
- Охин компанид өмнө нь эзэмшиж байсан хувьцааны бодит үнэ цэн.

Шилжүүлсэн төлбөрийг мөн адил бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Худалдан авалттай холбоотой гарсан зардлыг гарсан үед нь зардалд тооцон бүртгэнэ.

3 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

Худалдан авсан тодорхойлогдох цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнээс доор дурдсан зүйлсийн илүү гарсан хэсгийг гүүдвил гэж бүртгэнэ. Үүнд:

- Шилжүүлсэн төлбөр;
- Худалдан авсан компанид өмнө нь эзэмшиж байсан хувьцааны худалдан авсан өдрөөрх бодит үнэ цэн;
- Худалдан авагчийн хяналтын эрхгүй хувь хэмжээ

Хэрэв эдгээр дүн нь худалдан авсан бизнесийн тодорхойлогдох цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнээс бага байвал зөрүүг хямд үнээр худалдан авалт хэмээн үзэж ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрнө.

Нэгдмэл хяналт бүхий ажил гүйлгээ. Нэгдмэл хяналттай бизнесийн нэгдэл гэдэг нь нэгдлийн өмнө буюу дараа нэгдсэн талууд нэгдмэл нэг хяналттай байх бөгөөд уг хяналт нь шилжихгүй болохыг хэлнэ.

Нэгдмэл хяналт бүхий ажил гүйлгээ нь бизнесийн нэгдлийн үед үлддэг учир, тухайн нэгдлийг худалдан авалтын аргыг ашиглан бүртгэх ба нягтлан бодох бүртгэлийн бодлого мөн адил байдлаар хэрэгждэг.

Хэрэв худалдан авалтын арга нь худалдан авалтын олз үүсгэж байвал, тухайн олсон олзыг Группийн хувьцаа эзэмшигчдийн өмчид шууд хүлээн зөвшөөрнө.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд. Охин компани гэж Групп (i) гүйцэтгэлд нь өндөр ач холбогдол бүхий үйл ажиллагааг чиглүүлэх эрхтэй, (ii) гүйцэтгэлээс хамаарсан хувьсах өгөөж хүртэх эрхтэй, болон (iii) эрх мэдлээ ашиглан хөрөнгө оруулагчийн өгөөжид нөлөөлөх хүчтэй компаниудыг хэлнэ. Охин компаниудыг хяналт нь Групп рүү шилжсэн өдрөөс эхлэн тайланд нэгтгэх ба уг хяналт байхгүй болсон өдрөөр тусгаарлана.

Охин компаниудын худалдан авалтыг бүртгэхэд худалдан авалтын аргыг ашигласан. Бизнесийн нэгдлээр худалдан авсан тодорхойлогдохуйц хөрөнгүүд, өр төлбөрүүд, болзошгүй өр төлбөрүүдийг хяналтын бус хувь оролцоо байгаа эсэхээс үл хамааран худалдаж авсан өдрөөрх бодит үнэ цэнээр нь бүртгэнэ.

Гүүдвиллийг тооцохдоо худалдан авсан компанид төлсөн дүн, хяналтын бус хувь оролцооны дүн, худалдан авахын өмнөх өдрөөрх эзэмшиж байсан хувь оролцооны бодит үнэ цэнийн нийлбэрээс худалдан авсан компанийн цэвэр хөрөнгийг хасаж тооцно. Сөрөг дүнг ("сөрөг гүүдвилл" эсвэл "хямд үнээр худалдан авалт") менежмент худалдан авсан бүх хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг тодорхойлсон эсэхээ шалгаж, хэмжилтийн оновчтой эсэхийг нягталсны дараагаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Охин компанийг худалдан авахад төлсөн дүнг хэмжихдээ хүлээлгэн өгсөн хөрөнгө, гаргасан хувьцаа, үүссэн өр төлбөрийн бодит үнэ цэнэ дээр үндэслэнэ. Ингэхдээ болзошгүй заалтаарх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг оруулах ба худалдан авалттай холбоотой зөвлөх, хуулийн, үнэлгээ зэрэг мэргэжлийн үйлчилгээний хөлсийг оруулахгүй. Хувьцаа худалдан авах болон гаргахтай холбоотой гүйлгээний зардлыг эздийн өмчөөс хасна; бизнесийн нэгдэлтэй холбоотойгоор гаргасан өрийн үнэт цаастай холбоотой гүйлгээний зардлыг өр төлбөрийн дансны үнээс хасах ба худалдан авалттай холбоотой бусад бүх гүйлгээний зардлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Группийн компаниуд хоорондох компани хоорондын гүйлгээ, үлдэгдэл, хэрэгжээгүй олзыг устгана; өртгийг нь нөхөж үл чадахаас бусад тохиолдолд хэрэгжээгүй гарзыг мөн устгана. Компани болон түүний бүх охин компаниуд нь Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцтэй жигд бодлого ашигладаг.

Гадаад валютын хөрвүүлэлт. Группийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны мөнгөн тэмдэгт юм. тусдаа бүртгэлийн болон толилуулгын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг ("төгрөг") юм.

Охин компани дахь хөрөнгө оруулалт. Охин компани дахь хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэх ба худалдан авахад төлсөн дүнгээр хэмжинэ. Өртгөөр нь бүртгэсэн хөрөнгө оруулалтад дахин хэмжилт хийхгүй. Ийм хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн санхүүгийн тайланд үл хүлээн зөвшөөрөх, эсвэл үнэ цэнийн бууралт бүртгэх хүртэл анхны өртгөөр тайлагнана.

4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол, үнэлэлт

Гүйлгээ болон үлдэгдэл дүнгүүд. Гадаад валютаар солигдох мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг бүртгэлийн мөнгөн тэмдэгт рүү тухайн тайлагналын эцсийн өдрийн Монголбанк ("МБ")-ны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг Группийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт рүү МБ-ны жилийн эцсийн албан ханшаар хөрвүүлснээс үүсэх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Зээлтэй холбоотой гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд "санхүүгийн орлого эсвэл санхүүгийн зардал"-аар толилуулна. Бусад бүх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд "Бусад олз/(гарз), цэвэр дүн"-ээр толилуулна. Жилийн эцсийн ханшаарх хөрвүүлэлт нь түүхэн өртгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсэд хамаарахгүй. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг, түүний дотор өмчийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийг нь тодорхойлсон өдрийн ханшийг ашиглан хөрвүүлдэг.

Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлс дэх валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөг бодит үнэ цэнийн олз эсвэл гарзаар бүртгэдэг.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх гадаад валютаар илэрхийлэгдсэн балансын данснуудыг хөрвүүлэхэд ашигласан албан ханш 1 ам.дол = 3,420.25 төг (2023: 1 ам.дол = 3,410.69 төг), 1 вон = 2.32 төг (2023: 1 вон = 2.65 төг), 1 юань = 468.57 (2023: 1 юань = 480.01), 1 евро = 3,566.98 төг (2023: 1 евро = 3,791.66 төг) байсан. Орлого, зардлыг хөрвүүлэхэд ашигласан валютын дундаж ханш нь гүйлгээ хийсэн өдрийн хаалтын ханш байсан.

Групп нь нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүд болон дараагийн санхүүгийн тайлант жилийн хөрөнгө болон өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд нөлөө үзүүлэх үнэлэлт болон тооцооллыг хийдэг. Тооцоолол болон үнэлэлтүүд нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилдаг. Удирдлага нь тооцоололд үнэлэлт хийхийн зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцыг мөн үнэлдэг. нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлох нь ижил төстэй хөрөнгүүдийг ашиглаж үзсэн туршлагад тулгуурладаг. Ирээдүйн эдийн засгийн өгөөж нь энэхүү хөрөнгийн ашиглалтаас орж ирнэ. Хэдий тийм ч, техникийн болон хоцрогдол, биет элэгдэл хорогдуулалт зэрэг үзүүлэлтүүдээс хамааран хөрөнгөд агуулагдаж буй эдийн засгийн өгөөж буурдаг. Группийн удирдлага нь хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацааны шинжилгээг одоогийн техникийн нөхцөл байдал болон хөрөнгийн ирээдүйд өгөх үр ашигт тулгуурлан явуулдаг. Энд: (а) хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалт, (б) хүлээгдэж буй биет элэгдэл хорогдуулалт, энэ нь засвар үйлчилгээ болон үйл ажиллагааны хүчин зүйлсээс хамаарах, (в) эдийн засгийн нөхцөл байдалд орж буй өөрчлөлтөөс хамаарч буй техникийн болон хэрэглээний хоцрогдол зэрэг үндсэн хүчин зүйлсийг авч үздэг.

Түрээс. Групп нь талбай, тээврийн хэрэгсэл болон агуулах түрээслэдэг. Түрээсийн гэрээг ихэвчлэн 3-аас 9 жил хүртэл тогтмол хугацаанд хийдэг. Групп нь түрээсийн хэрэгжих хугацааг эдийн засгийн үр өгөөж дээр тулгуурлан тодорхойлдог. Тодорхойлогдсон торгуулийн үр нөлөөг харгалзан үзэн, материаллаг нөлөөгүй бол түрээсийн хэрэгжих хугацааг гэрээний хугацаанаас уртаар хэрэгжүүлж болно.

Түрээсийн тооцоололд нуугдмал хүүгийн түвшинг шууд тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшинг ашиглана. Төгрөгөөр илэрхийлэгдсэн түрээсүүдэд 16% дискаунтын хувийг ашигласан.

Алдагдлын нөөц сангийн тооцоолол. Групп нь найдваргүй авлагын хасагдуулгыг харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал болон холбогдох салбарын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тооцоолдог.

Энэ тохиолдолд удирдлагын үнэлгээ нь харилцагч талын нөхцөл байдал, харилцаа холбоо, түүний талаарх тодорхой байгаа зах зээлийн мэдээлэл болон зээлийн талаарх мэдээ тайлан зэрэг дээр үндэслэн хийгддэг. Групп нь цуглуулагдахаар хүлээгдэж буй дүнг илэрхийлэх үүднээс хасагдуулгыг удирдлагын үнэлгээний дагуу тооцоолдог. Энэхүү тусгайлсан хасагдуулгын тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол, үнэлэлт (Үргэлжлэл)

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолох. Цэвэр боломжит үнэ цэн гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Гэмтэлтэй, хоцрогдсон болон удаан хугацаанд хөдөлгөөнд ороогүй бараа материал байгаа эсэхийг удирдлагын зүгээс тогтмол хянадаг.

Групп өөрийн тооцооллыг үнэн зөв, бодитой гэж үзэж байгаа боловч аливаа бодит нөхцөл байдал эсвэл нөлөө бүхий хүчин зүйлсээс шалтгаалан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд ашиг, алдагдал болон өмчид материаллагаар нөлөө үүсч болзошгүй.

Монгол Улсын татварын систем. Монгол Улсын Засгийн Газар зах зээлийн эдийн засагт шилжихдээ бизнес, худалдааны дэд бүтцийн шинэчлэлийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнест нөлөөлж буй хууль тогтоомжууд хурдацтай өөрчлөгдсөөр байна.

Хэд хэдэн эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль ногдуулах хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Татварын хууль тогтоомжийн талаарх ойлголтдоо үндэслэн бүх татварын өр төлбөрийг зохих ёсоор хангасан гэж Групп үзэж байгаа ч дээрх баримтууд нь Группд татварын эрсдэлийг үүсгэж болзошгүй юм.

Хойшлогдсон орлогын албан татвар. Групп нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолохдоо Монгол Улсын хуулиар тогтоосон татварын хувь хэмжээ, татвараас хасагдахгүй зардлууд, татварын хуульд орсон өөрчлөлтүүд болон удирдлагын хүлээж буй ирээдүйн үр дүн зэргийг харгалзаж үздэг. Хойшлогдсон орлогын албан татварыг түр зөрүүн дээр суурилан тооцоолдог ба энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлагнасан орлого, зардал болон татварын хуулийн дагуу тодорхойлсон татвар ногдох орлого, зардлын хоорондох зөрүү юм. Эдгээр түр зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг нэгтгэсэн санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр тусгадаг.

Группийн удирдлага нь хойшлогдсон татварын хөрөнгө хэрэгжихгүй гэж үзэж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй. Бодит үр дүн нь энэ таамаглалаас зөрүүтэй байх тохиолдолд ирээдүйн тайлант үеүдэд уг таамаглалын залруулга хийх ба тайлант жилийн санхүүгийн байдал болон орлогод материаллаг нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэх шаардлага тулгарч болно.

5 СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон тайлант жилд заавал хэрэгжиж эхэлсэн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон тухайн өдрөөс хойш хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг Групп тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2024 оны 01 дүгээр сарын 01	• Шалгуур үзүүлэлт бүхий эргэлтийн бус өр төлбөр – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд
	• Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд
	• Борлуулаад буцаан түрээслэх ажил гүйлгээний түрээсийн өр төлбөр – СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлтүүд
	• Бэлтгэн нийлүүлэгчийн санхүүжилтийн тохиролцоо – НББОУС 7 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд

Тайлант жилд хэрэгжүүлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант жилийн Группийн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, тэдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

6 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй шинэ стандартууд болон СТОУС-д орсон нэмэлт өөрчлөлтүүд

Нягтлан бодох бүртгэлийн хэд хэдэн шинэ стандартууд нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хойших тайлант жилүүдэд хэрэгжиж эхлэх бөгөөд мөрдөгдөж эхлэх хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Гэхдээ Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах шинэ эсвэл нэмэлт өөрчлөлт орсон стандартуудыг хэрэгжүүлж эхлээгүй байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх огноо	Нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2025 оны 01 дүгээр сарын 01	Арилжаалагдах боломж бага – НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлтүүд
2026 оны 01 дүгээр сарын 01	- Санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт – СТОУС 9 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд - СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын жил бүрийн сайжруулалт – 11-р хэвлэл
2027 оны 01 дүгээр сарын 01	- СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга - СТОУС 19 Олон нийтэд хамааралгүй охин компаниуд: Тодруулга
Сонголттойгоор мөрдөх боломжтой / мөрдөх хугацааг тодорхойгүйгээр хойшлуулсан	Хөрөнгө оруулагч болон түүний хараат эсвэл хамтарсан компани хоорондын борлуулалт болон хувь оруулсан хөрөнгө – СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд

Групп СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга стандартаас бусдаар дээрх шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2027 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэх болон түүнээс хойших тайлант жилүүдэд СТОУС 18 нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартыг орлоно. Шинэ стандартаар дараах үндсэн шинэ шаардлагуудыг танилцуулсан.

- Компаниуд бүх орлого, зардлыг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилт, зогсоосон үйл ажиллагаа болон орлогын татвар гэсэн таван үндсэн төрөлд ангилах шаардлагатай. Компаниуд мөн шинээр тодорхойлсон үйл ажиллагааны ашгийн дүнг толилуулах шаардлагатай болсон. Компанийн цэвэр ашгийн дүн өөрчлөгдөхгүй.
- Удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүр ("УТГХ") нь санхүүгийн тайланд тусдаа тодруулгаар толилуулагдана.
- Санхүүгийн тайланд мэдээллийг хэрхэн бүлэглэх талаар дэлгэрэнгүй удирдамж гарсан.

Түүнээс гадна, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд бус аргаар толилуулж байгаа тохиолдолд компаниуд мөнгөн гүйлгээний тайланг үйл ажиллагааны ашгийн дүнгээс эхлэх шаардлагатай.

Групп шинэ стандартын, ялангуяа Группийн ашиг, алдагдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн бүтэц болон УТГХ-ээр шаардсан нэмэлт тодруулгын нөлөөг үнэлэх шатандаа явж байна. Мөн Групп нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг хэрхэн цаашид бүлэглэх, тэр дундаа одоогоор 'бусад' гэж тэмдэглэсэн зүйлсүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна.

7 Сегментийн мэдээлэл

Үйл ажиллагааны сегмент гэж орлого олох эсвэл зардал гаргах боломжтой бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, үйл ажиллагааны үр дүнг үйл ажиллагааны ахлах шийдвэр гаргагч (ҮААШГ) тогтмол хянаж үздэг бөгөөд санхүүгийн хувьд салангид мэдээлэл авах боломжтой бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлнэ. ҮААШГ нь байгууллагын нөөцийг хуваарилж, гүйцэтгэлийг үнэлдэг хүн эсвэл бүлэг хүмүүс юм. Группийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагыг ҮААШГ гэж тодорхойлсон ба ҮААШГ нь бизнесийн нэг сегментийг тодорхойлсон. Группийн үйл ажиллагаа стратегийн бизнесийн нэгжүүдээс бүрддэг ба өөр өөр бүтээгдэхүүн, үйлчилгээнд анхаарлаа төвлөрүүлдэг боловч нэг бизнесийн нэгж мэтээр хамтран удирдаж, нэгдсэн маркетингийн стратеги болон үйлчилгээний түвшинг шаарддаг тул тайлагнах нэг сегмент гэж тодорхойлсон. Мөн Группийн бизнесийн тус бүрийн үйл ажиллагаанд хамаарах санхүүгийн мэдээлэл байхгүй болно.

Иймээс эдгээр санхүүгийн тайлангууд нэг тайлагнах сегментийн үндсэн дээр бэлтгэгдсэн. Группийн бизнесийн үйл ажиллагаа тус бүрийн тайлагнасан орлогийг Тодруулга 25-д тусгасан болно. Нэг харилцагчтай хийсэн гүйлгээнээс олсон орлого Группийн нийт орлогын 10 хувийг давахгүй. Группийн үйл ажиллагаа нь Монгол Улсад явагддаг ба Группийн бүх хөрөнгө Монгол Улсад байрладаг.

8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд

2024 онд Групп Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Реүстинг ХХК болон Стора Централ ХХК гэх компаниудыг бизнесийн нэгдлээр худалдан авсан. Тодруулга 11 болон 33-аас харна уу.

Групп 2024 оны 2 дугаар сарын 9-ний өдөр Премиум Коммерс ХХК нэртэй охин компанийг бөөний худалдаа эрхлэх үндсэн үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулсан.

Групп 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Премиум Нэксус Ложистик ХХК нэртэй охин компанийг ложистик, тээврийн үндсэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгдмэл хяналттай компаниудад Премиум Групп ХХК, Премиум Конкрит ХХК, Премиум Бьюлдинг Материалс ХХК, Премиум Иннова ХХК, Премиум Прожектс ХХК, Премиум Новелти ХХК, Премиум Майнинг Сервисэс ХХК, Аркадиа Гарден ХХК, Ад Сمارт Нэтворк ХХК, Фоур Сийсонс Фарминг ХХК, Сүлд Итгэл Соёомбо ХХК, Юу Эм Эс ХХК, Финко Капитал ББСБ ХХК болон Эдмикс Химикалс ХХК багтана. Бусад холбоотой талуудад Группийн хувьцаа эзэмшигчид шууд болон шууд бус байдлаар талаас илүү хувийг нь эзэмшдэг эсвэл өөрөөр үйл ажиллагаанд нь хяналт тавих эрхтэй байгууллагууд багтана. Удирдлагын эрх бүхий албан тушаалтны бүрэлдэхүүнд Гүйцэтгэх захирал болон Газрын захирлууд хамаарна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн холбоотой талуудын дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаа эзэмшигчид	Нэгдмэл хяналттай компаниуд	Бусад холбоотой талууд
Дансны ба бусад авлага	16	-	448,425	-
Зээл	19	2,063,762	19,849	-
Дансны ба бусад өглөг	23	2,428,393	92,468	275,414
Бусад урт хугацаат өр төлбөр		711,257	-	-

Бүх ажил гүйлгээнүүд арилжааны энгийн нөхцөл болон зах зээлийн хувь хэмжээнд үндэслэн хийгдсэн. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудтай хийсэн гүйлгээ дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Хувьцаа эзэмшигчид	Нэгдмэл хяналттай компаниуд	Бусад холбоотой талууд
Бэлэн бүтээгдэхүүний худалдан авалт	10,534,074	2,910	5,005,220
Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт	-	227,372	-
Үзүүлсэн үйлчилгээ	-	4,506	-
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	-	42,184	-
Хүүгийн зардал	212,883	358,646	-
Бусад орлого	-	75,519	-
Бусад зардал	5,863,403	197,005	-
Гаргасан хувьцаа	5,120,900	30,000,000	-

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд (Үргэлжлэл)

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгдмэл хяналттай компаниуд нь Премиум Групп ХХК, Премиум Конкрит ХХК, Премиум Бьюлдинг Материалс ХХК, Премиум Прожектс ХХК, Премиум Новелти ХХК, Юу Эм Эс ХХК, Премиум Майнинг Сервисэс ХХК, Премиум Корпорэйшн ХХК, Стора Централ ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК, Чингис Шар Айраг ХХК, Чингис Шар Айраг Клуб ХХК болон Аркадиа Гарден ХХК багтана. Бусад холбоотой талуудад Группийн хувьцаа эзэмшигчид шууд болон шууд бус байдлаар талаас илүү хувийг нь эзэмшдэг эсвэл өөрөөр үйл ажиллагаанд нь хяналт тавих эрхтэй байгууллагууд багтана. Удирдлагын эрх бүхий албан тушаалтны бүрэлдэхүүнд Гүйцэтгэх захирал болон Газрын захирлууд хамаарна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн холбоотой талуудын дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаа эзэмшигчид	Нэгдмэл хяналттай компаниуд	Бусад холбоотой талууд
Урьдчилгаа	15	-	48,535	-
Бусад авлага	16	8,334	12,475	-
Зээл	19	8,075,713	2,010,964	-
Дансны ба бусад өглөг	23	3,006,656	30,226,712	974,916
Үндсэн хөрөнгө авахтай холбоотой өглөг		191,880	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		709,269	-	-

Бүх ажил гүйлгээнүүд арилжааны энгийн нөхцөл болон зах зээлийн хувь хэмжээнд үндэслэн хийгдсэн. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудтай хийсэн гүйлгээ дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Хувьцаа эзэмшигчид	Нэгдмэл хяналттай компаниуд	Бусад холбоотой талууд
Бэлэн бүтээгдэхүүний худалдан авалт	2,384,098	10,705,205	6,986,823
Үзүүлсэн үйлчилгээ	1,023,331	-	-
Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт	-	28,944	941
Үндсэн хөрөнгийн борлуулалт	-	4,682	-
Хүүгийн зардал	370,511	283,061	-
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	-	7,406,833	-
Бусад зардал	3,924,232	-	-

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансны үлдэгдлүүд (Үргэлжлэл)

Группийн эрх бүхий 26 албан тушаалтнуудад олгосон цалин урамшуулал дараах байдалтай байна (2023: 10 эрх бүхий албан тушаалнууд):

Мянган төгрөгөөр	2024	2023
<i>Богино хугацааны тэтгэмж:</i>		
- Цалин хөлс	3,160,198	1,301,125
- Богино хугацааны урамшуулал	1,552,035	-
<i>Хөдөлмөр эрхлэлтийн дараах тэтгэмж:</i>		
-Нийгмийн даатгалын шимтгэл	568,558	162,584
Нийт дүн	5,280,791	1,463,709

Богино хугацааны цалин урамшуулал нь удирдлагын холбогдох үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаанаас хойш арван хоёр сарын дотор бүрэн төлөгддөг.

Премииум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусааар болсон тайлант жил

9 Үндсэн хөрөнгө

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Барилга	Тоног төхөөрөмж	Машин, тээврийн хэрэгсэл	Тавилга, оффисын тоног төхөөрөмж	Газар, газрын сайжруулалт	Түрээсийн сайжруулалт	Дуусаагүй барилга	Нийт дүн
2023 оны 01 дүгээр сарын 01-ээрх өртөг	12,334,697	4,932,504	1,101,690	41,083,713	47,964	25,016,885	2,306,292	86,823,745
Хуримтлагдсан элэгдэл	(664,122)	(864,238)	(386,701)	(12,759,046)	(335)	(4,811,210)	-	(19,485,652)
2023 оны 01 дүгээр сарын 01-ээрх дансны үнэ	11,670,575	4,068,266	714,989	28,324,667	47,629	20,205,675	2,306,292	67,338,093
Нэмэгдсэн Дахин ангилсан Борлуулсан (өртөг)	4,151,777	5,510,657	462,231	8,467,665	-	15,765,799	3,500	34,361,629
Борлуулсан (элэгдэл)	-	-	96,661	9,136,463	-	(9,233,124)	-	-
Данснаас хассан (өртөг)	-	(44,065)	(60,000)	(159,408)	-	-	(2,309,792)	(2,573,265)
Данснаас хассан (элэгдэл)	-	10,979	28,197	118,778	-	-	-	157,954
Данснаас хассан (элэгдэл)	-	-	-	(912,578)	-	-	-	(912,578)
Тайлант жилийн элэгдлийн зардал	(587,452)	(566,745)	(144,724)	(9,527,363)	(908)	(3,843,603)	-	(14,670,795)
2023 оны 12 дугаар сарын 31-ээрх өртөг	16,486,474	10,399,096	1,600,582	57,615,855	47,964	31,549,560	-	117,699,531
Хуримтлагдсан элэгдэл	(1,251,574)	(1,420,004)	(503,228)	(21,416,686)	(1,243)	(8,654,813)	-	(33,247,548)
2023 оны 12 дугаар сарын 31-ээрх дансны үнэ	15,234,900	8,979,092	1,097,354	36,199,169	46,721	22,894,747	-	84,451,983
Бизнесийн нэгдэл (Тодруулга 33)	12,499,873	1,438,477	2,080,155	528,783	2,943,783	110,470	-	19,601,541
Нэмэгдсэн Борлуулсан (өртөг)	1,040,980	3,225,816	2,390,312	20,075,999	-	7,789,398	-	34,522,505
Борлуулсан (элэгдэл)	-	(46,330)	(1,230,692)	(371,698)	-	(126,916)	-	(1,775,636)
Данснаас хассан (өртөг)	-	9,156	544,451	59,675	-	-	-	613,282
Данснаас хассан (элэгдэл)	-	(9,923)	(38,435)	(500,177)	-	-	-	(548,535)
Тайлант жилийн элэгдлийн зардал	(1,608,602)	(1,359,353)	(526,545)	(10,772,870)	(12,156)	(4,895,456)	-	(19,174,982)
2024 оны 12 дугаар сарын 31-ээрх өртөг	30,027,327	15,007,136	4,801,922	77,348,762	2,991,747	39,322,512	-	169,499,406
Хуримтлагдсан элэгдэл	(2,860,176)	(2,765,040)	(448,520)	(31,728,542)	(13,399)	(13,550,269)	-	(51,365,946)
2024 оны 12 дугаар сарын 31-ээрх дансны үнэ	27,167,151	12,242,096	4,353,402	45,620,220	2,978,348	25,772,243	-	118,133,460

2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар газрын дансны үнэ нь 2,957,838 мянган төгрөг (2023: 25,300 мянган төгрөг) байсан.
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилд бараа материалд 208,503 мянган төгрөгийн (2023: тэг) элэгдлийн зардлыг капиталжуулсан.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

9 Үндсэн хөрөнгө (Үргэлжлэл)*Барьцаалсан хөрөнгө*

Групп өөрийн эзэмшлийн 58,559,312 мянган төгрөгийн дансны үнэ бүхий машин, тээврийн хэрэгсэл болон үндсэн хөрөнгийг Голомт банкнаас авсан зээлийн барьцаанд тавьсан. Тодруулга 19-ийг харна уу.

10 Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр

Групп нь дэлгүүрийн талбай, тээврийн хэрэгсэл болон агуулах түрээслэдэг. Түрээсийн гэрээг ихэвчлэн 3-аас 9 жил хүртэл тогтмол хугацаанд хийдэг. Групп нь түрээс тус бүрийн хэрэгжих хугацааг тодорхойлохдоо, түүний эдийн засгийн үр өгөөжийг харгалзан үзэж тодорхойлдог. Эдийн засгийн үр өгөөж гэдэгт томоохон хэмжээний торгууль эсвэл алдагдлыг хамруулан үздэг. Групп гэрээний өдөр тухайн түрээсийн үргэлжлэх хугацааг түрээсийн гэрээний хугацаанаас уртаар тогтоож болох ба энэ хугацаа нь гэрээ цуцалснаар үүсэх торгууль эсвэл алдагдлын хэмжээ бага болох хүртэл байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ашиглах эрхтэй хөрөнгийн өөрчлөлт дараах байдалтай байна:

<i>Мянган төгрөгөөр</i>	Талбай	Агуулах	Нийт дүн
2023 оны 01 дүгээр сарын 01-ээрх дансны үнэ	46,960,531	-	46,960,531
Нэмэгдсэн	16,371,139	-	16,371,139
Хасагдсан	(1,050,049)	-	(1,050,049)
Элэгдлийн зардал	(11,749,379)	-	(11,749,379)
2023 оны 12 дугаар сарын 31-ээрх дансны үнэ	50,532,242	-	50,532,242
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн (Тодруулга 33)	328,240	966,641	1,294,881
Нэмэгдсэн	28,462,352	2,541,015	31,003,367
Хасагдсан	(9,612,743)	-	(9,612,743)
Элэгдлийн зардал	(12,027,624)	(621,494)	(12,649,118)
2024 оны 12 дугаар сарын 31-ээрх дансны үнэ	57,682,467	2,886,162	60,568,629

2024 онд хасагдсан ашиглах эрхтэй хөрөнгө нь дамжуулан түрээслэсэн гэрээнүүдтэй холбоотой ба холбогдох санхүүгийн түрээсийн авлагын хүлээн зөвшөөрсөн.

Групп дараах түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн:

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Богино хугацаат түрээсийн өр төлбөр	17,695,275	12,079,710
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	64,535,185	56,622,145
Нийт түрээсийн өр төлбөр	82,230,460	68,701,855

2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хүүгийн зардал нь 11,916,941 мянган төгрөг (2023: 10,292,530 мянган төгрөг) байна. Тодруулга 29-өөс харна уу.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

10 Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр (Үргэлжлэл)

Богино хугацаат түрээс болон бага үнэтэй хөрөнгийн түрээс болон хувьсах түрээсийн төлбөр дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024	2023
Богино хугацаат түрээстэй холбоотой зардал	1,104,134	557,561
Богино хугацаат түрээсээр тусгагдаагүй бага үнэтэй хөрөнгийг түрээслэхтэй холбогдон гарсан зардал	29,916	259,248
Орлого дээр суурилсан хувьсах түрээсийн төлбөр	2,140,708	1,885,836

Түрээсийн гэрээнүүдээр түрээслүүлэгчийн эзэмшиж буй түрээсийн хөрөнгийн аюулгүй байдлаас өөр бусад үүрэг хариуцлага түрээсийн хөрөнгийн хувьд хүлээгээгүй. Зээл авахдаа түрээсийн хөрөнгийг барьцаалдаггүй.

Премииум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

11 Биет бус хөрөнгө

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан биет бус хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Гүүдвил	Худалдааны нэр	Газар ашиглах эрх	Франчайзын төлбөр	Программ хангамжийн лиценз	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
2023 оны 01 дүгээр сарын 01-нээсх үлдэгдэл	-	-	1,393,825	1,268,740	3,152,992	38,960	5,854,517
Нэмэгдсэн	-	-	-	-	1,146,404	-	1,146,404
Хасагдсан	-	-	(86,440)	-	-	(33,485)	(119,925)
Хорогдуулалтын зардал	-	-	(118,897)	(239,447)	(772,721)	(5,475)	(1,136,540)
2023 оны 12 дугаар сарын 31-нээсх үлдэгдэл	-	-	1,188,488	1,029,293	3,526,675	-	5,744,456
Бизнесийн нэгдэл (Тодруулга 33)	668,186	32,219,618	-	-	581,733	20,894	33,490,431
Нэмэгдсэн	-	-	-	-	1,788,143	33,769	1,821,912
Хорогдуулалтын зардал	-	-	(114,259)	(240,046)	(917,740)	(10,711)	(1,282,756)
2024 оны 12 дугаар сарын 31-нээсх үлдэгдэл	668,186	32,219,618	1,074,229	789,247	4,978,811	43,952	39,774,043
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө, биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлыг хуваарилалт:							
Мянган төгрөгөөр			2024			2023	
Борлуулалтын өртөг (Тодруулга 26)			30,332,205			25,719,581	
Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал (Тодруулга 27)			2,566,148			1,837,133	
Бараа материалд капиталжуулсан			208,503			-	
Нийт элэгдэл, хорогдууллын зардал			33,106,856			27,556,714	

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

12 Санхүүгийн түрээсийн авлага

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Богино хугацаат түрээсийн авлага	3,119,136	1,502,377
Урт хугацаат түрээсийн авлага	10,031,970	8,238,816
Нийт санхүүгийн түрээсийн авлага	13,151,106	9,741,193

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Групп нь 73 дэлгүүрийн байр (2023: 47)-ыг дамжуулан түрээслүүлж байсан ба эдгээрийг дэлгүүрийн байрыг франчайз эрх хүлээн авагчидад түрээслэсэн.

2024 онд санхүүгийн түрээстэй холбоотой 2,016,301 мянган төгрөг (2023: 879,968 мянган төгрөг)-ийн хүүгийн орлогыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 30-аас харна уу.

Түрээсийн авлагын дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ их хэмжээний зөрүүгүй. Групп хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихдээ СТОУС 9-ийн хялбаршуулсан аргыг ашигладаг бөгөөд түрээсийн авлагад хугацааны турш дахь хүлээгдэж буй алдагдлын нөөц санг ашигладаг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцоолохдоо санхүүгийн түрээсийн авлагыг зээлийн эрсдэлийн онцлог шинж болон хугацаа хэтэрсэн хоногуудад үндэслэн ангилдаг.

Хүлээгдэж буй алдагдлын хувь хэмжээг тооцоолоход тайлант хугацаа дуусахаас өмнөх 36 сарын түрээсийн төлбөрийн мэдээлэл болон тус хугацаанд холбогдох зээлийн алдагдлын түүхэн мэдээллийг ашиглагддаг. Өнгөрсөн хугацааны түүхэн алдагдлын хувь хэмжээг түрээслэгчдийн авлагыг барагдуулах чадварт нөлөөлж буй макро эдийн засгийн хүчин зүйлсийн талаарх одоогийн болон хэтийн мэдээллийг тусгах үүднээс тохируулсан.

2024 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп нь ХБЭА-ыг хүлээн зөвшөөрөөгүй ба ХБЭА нь тухайн өдрийн байдлаар материаллаг бус байна.

Санхүүгийн түрээсийн авлагын хугацааны дуусгавар болох хугацааны шинжилгээ дараах байдалтай байна:

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
1 жил	4,937,458	3,142,292
2 жил	4,921,907	3,142,812
3 жил	4,932,319	3,142,812
4 жил	1,834,519	3,142,812
5 жил	447,417	979,872
5 жилээс дээш	233,675	40,303
12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн түрээсийн авлагын хорогдуулаагүй нийт дүн	17,307,295	13,590,903
Хэрэгжээгүй санхүүгийн орлого	(4,156,189)	(3,849,710)
12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн түрээсийн авлага	13,151,106	9,741,193

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

13 Зээлийн авлага

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Байгууллагын зээл:		
Богино хугацаат зээл	47,049	-
Урт хугацаат зээл	27,599	2,000,000
12 дугаар сарын 31-ний өдрөөрх хорогдуулсан өртгөөрх зээлийн дансны нийт дүн	74,648	2,000,000

14 Бараа материал

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Бэлэн бүтээгдэхүүн	40,830,744	22,579,634
Шууд материал	2,252,038	647,059
Хангамжийн материал	1,597,624	1,160,276
Замд яваа бараа	1,970,040	3,674,810
Барилгын материал	544,062	188,250
12 дугаар сарын 31-ээрх нийт бараа материалын дүн	47,194,508	28,250,029

Тайлант хугацаанд борлуулалтын өртгөөр дамжуулан нэгтгэсэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн борлуулсан бараа материалын өртөг 364,516,060 мянган төгрөг (2023: 256,813,791 мянган төгрөг) байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн акталсан бараа материалын дүн 16,708,543 мянган төгрөг (2023: 24,535,796 мянган төгрөг) байсан. Үүнийг тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрсөн ба нэгтгэсэн санхүүгийн тайланд борлуулалтын өртөгт тусгасан.

15 Урьдчилгаа

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Эргэлтийн:		
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	7,326,359	1,712,778
Холбоотой талуудад төлсөн урьдчилгаа	-	48,535
Нийт эргэлтийн урьдчилгаа	7,326,359	1,761,313
Эргэлтийн бус:		
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа – тоног төхөрөмж	2,580,879	770,655
Нийт эргэлтийн бус урьдчилгаа	2,580,879	770,655
Нийт урьдчилгаа	9,907,238	2,531,968

Премиум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жил

16 Дансны ба бусад авлага

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024	2023
Гуравдагч талуудаас авах дансны авлага		6,387,020	592,980
Холбоотой талуудаас авах дансны авлага	8	436,000	20,809
Гуравдагч талуудаас авах бусад авлага		824,694	926,153
Холбоотой талуудаас авах бусад авлага	8	12,425	-
Дансны ба бусад авлага дахь нийт санхүүгийн хөрөнгө		7,660,139	1,539,942
Ажилчдаас авах авлага		318,844	92,428
НӨАТ болон бусад татварын авлага		2,350,875	2,043,607
Дансны ба бусад авлага дахь нийт бус санхүүгийн хөрөнгө		2,669,179	2,136,035
Нийт дансны ба бусад авлага – 12 дугаар сарын 31-ээрх		10,329,858	3,675,977
Урт хугацаат дансны болон бусад авлага		2,381,209	2,160,078
Богино хугацаат дансны болон бусад авлага		10,329,858	3,675,977

Дансны авлагын үлдэгдэл нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй.

Групп хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихэд СТОУС 9-ийн хялбаршуулсан аргыг ашигладаг бөгөөд энэ нь дансны авлагын хувьд хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжихийн тулд дансны авлагууд зээлийн эрсдэлийн онцлог шинж болон хугацаа хэтэрсэн өдрүүдэд үндэслэн ангилагдсан.

Хүлээгдэж буй алдагдлын түвшин нь тайлангийн өдрөөс өмнөх 3 сарын хугацаанд хийсэн борлуулалтын дүнд үндэслэн энэ хугацаанд тохиолдсон холбогдох түүхэн эрсдэлийн алдагдалд үндэслэгддэг. Түүхэн алдагдлын түвшин нь харилцагчдын авлагыг барагдуулах чадварт нөлөөлж буй макро эдийн засгийн хүчин зүйлсийн одоогийн болон ирээдүйн мэдээллийг харгалзан тохируулагддаг.

2024 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп нь ХБЭА-ыг хүлээн зөвшөөрөөгүй ба ХБЭА нь тухайн өдрийн байдлаар материаллаг бус байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бусад авлагатай холбоотой тооцсон эрсдэлийн алдагдлын хасагдуулгагүй байсан.

Эрсдэлийн алдагдлын хасагдуулгын хөдөлгөөн дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024	2023
01 дүгээр сарын 01-ээрх эрсдэлийн алдагдлын хасагдуулга	-	-
Тайлант жилд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нэмэгдэл	566,913	37,447
Данснаас хассан	(566,913)	(37,447)
12 дугаар сарын 31-ээрх эрсдэлийн алдагдлын хасагдуулга	-	-

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

17 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	2024	2023
Бэлэн мөнгө	560,514	840,894
Банкны харилцах дансанд буй мөнгөн хөрөнгө	9,871,019	2,139,691
12 дугаар сарын 31-ээрх нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,431,533	2,980,585

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үнэ нь бодит цэнээсээ материаллаг зөрүүгүй.

2024 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ХБЭА-ын дүн эдгээр өдрүүдийн байдлаар материаллаг бус хэмжээтэй байсан.

Дараах хүснэгтэд 2024 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжилтийн чанарыг зээлийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нэгтгэн харууллаа. Группын зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн талаарх тайлбарыг Тодруулга 36-аас харна уу.

Мянган төгрөгөөр	2024	2023
- Хангалттай (В үнэлгээтэй)	9,871,019	2,139,691

18 Хувьцаат капитал ба нэмж төлөгдсөн капитал

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх энгийн хувьцаа болон нэмж төлөгдсөн капиталын дүн дараах байдалтай байна:

	Хувьцааны тоо (мянган ширхэг)	Мянган төгрөгөөр		
		Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Энгийн хувьцаа
2023 оны 12 дугаар сарын 31-ээрх	817,768	81,776,864	13,820,503	95,597,367
Шинээр гаргасан хувьцаа	296,483	29,648,339	32,020,206	61,668,545
Ажил гүйлгээний зардал	-	-	(82,793)	(82,793)
2024 оны 12 дугаар сарын 31-ээрх	1,114,251	111,425,203	45,757,916	157,183,119

2021 оны 11 дүгээр сард Компани Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр шинээр 137,960,969 ширхэг (Компанийн энгийн хувьцааны 16.87%) хувьцааг олон нийтэд гаргаж, нийтдээ 27,616,599 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн. Нэгж хувьцааг 208 төгрөгөөр гаргасан ба нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьцааны нэрлэсэн үнээс давсан хэсгээс арилжааны зардлыг хасан, зөрүү 13,820,503 мянган төгрөгийг нэмж төлөгдсөн капиталд бүртгэсэн.

2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Компани нь 61,668,545 мянган төгрөгөөр нийт 208 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 296,483,391 ширхэг энгийн хувьцааг гаргаснаар охин компаниудын хувьцааг эзэмшиж, бусад өглөг болон зээлийн үлдэгдлүүдийг тус тус хаасан. Тодруулга 33-ыг харна уу.

Нийт зөвшөөрөгдсөн энгийн хувьцааны тоо 1,114,251 мянган ширхэг (2023: 817,768 мянган ширхэг) нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг (2023: нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг) байна. Гаргасан бүх энгийн хувьцаа бүрэн төлөгдсөн. Энгийн хувьцаа бүр нэг саналын эрхтэй.

Нэмж төлөгдсөн капитал нь гаргасан нэгж хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн дүнг илэрхийлнэ.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

19 Зээл

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024	2023
Урт хугацаат:			
Гуравдагч талаас авсан зээл		21,337,394	26,331,673
Холбоотой талаас авсан зээл	8	2,051,849	7,550,342
Нийт урт хугацаат зээл		23,389,243	33,882,015
Богино хугацаат:			
Гуравдагч талаас авсан зээл		24,701,468	17,407,201
Холбоотой талаас авсан зээл	8	31,762	2,562,745
Нийт богино хугацаат зээл		24,733,230	19,969,946
Нийт зээл		48,122,473	53,851,961

Группийн зээлийг валютаар нь ангилан харуулбал:

Мянган төгрөгөөр	2024	2023
- Монгол Төгрөг	46,058,711	45,776,248
- Солонгос Вон	2,063,762	8,075,713
12 дугаар сарын 31-ээрх нийт зээлийн дүн	48,122,473	53,851,961

Группийн зээлүүдийн илэрхийлэгдэх валют болон хүүг дор харуулав (хүүгийн өр төлбөрийг оруулаагүй).

Мянган төгрөгөөр	Валют	Нэрлэсэн хүү (жилийн)	Зээлийн хугацаа	2024	2023
Арилжааны банк	Төгрөг	16.00%	2024.03.04	-	4,770,606
Арилжааны банк	Төгрөг	17.00%	2024.07.21	-	5,027,945
Холбоотой талаас авсан зээл	Төгрөг	17.10%	2024.12.19	-	2,010,964
Арилжааны банк	Төгрөг	15.00%	2025.03.31	576,765	-
Арилжааны банк	Төгрөг	10.00%	2025.03.31	339,361	-
Арилжааны банк	Төгрөг	18.00%	2026.04.30	2,472,552	-
Арилжааны банк	Төгрөг	15.00%	2026.07.21	8,408,192	-
Арилжааны банк	Төгрөг	15.00%	2026.07.31	3,335,521	-
Банк бус санхүүгийн байгууллага	Төгрөг	34.80%	2026.10.26	19,849	26,410
Арилжааны банк	Төгрөг	15.76%	2027.06.20	6,282,384	8,795,337
Холбоотой талаас авсан зээл	Вон	4.60%	2027.09.24	2,063,762	8,075,713
Арилжааны банк	Төгрөг	15.00%	2027.12.12	11,305,479	15,088,767
Арилжааны банк	Төгрөг	15.00%	2028.07.20	9,187,726	10,056,219
Арилжааны банк	Төгрөг	19.00%	2028.08.31	4,130,882	-
				48,122,473	53,851,961

19 Зээл (Үргэлжлэл)

Групп нь хейджийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэггүй бөгөөд гадаад валютын өр төлбөр, хүүгийн эрсдэлтэй холбоотой хейджийн гэрээ хийгээгүй болно. Зээлийн дансны үнэ нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байдаг.

Дээрх зээлийн гэрээнүүдэд зарим нэг санхүүгийн бус үүргийг биелүүлэхийг шаарддаг. Биелүүлээгүй тохиолдолд зээлийн гэрээг зөрчсөнд тооцох ба үлдэгдэл дүнг шууд төлж барагдуулах үүрэгтэй. Ийм учраас Санхүүгийн албанаас зээлийн үүргийн биелэлтийг улирал тутам хянадаг. 2024 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп бүх үүргийн биелэлтийг хангасан байна.

Компани нь тайлант жилд БиЖиЭф Ритэйл Лимитед Компаниас авсан зээлийн үлдэгдэл болох 5,120,900 мянган төгрөгт 24,620 мянган ширхэг энгийн хувьцааг хөрвүүлсэн. Тодруулга 18-ыг харна уу.

* Компанийн хувьцаа эзэмшигчид 320,016 ширхэг хувьцааг (2023: 1,583,914 ширхэг) Солонгос воноор авсан зээлийн барьцаанд тавьсан.

Барьцаанд тавьсан хөрөнгө

Компани өөрийн эзэмшлийн 58,559,312 мянган төгрөгийн дансны үнэтэй машин, тээврийн хэрэгсэл болон үндсэн хөрөнгийг Голомт банкнаас авсан зээлийн барьцаанд тавьсан.

20 Засгийн газрын тусламж

Засгийн газрын буцалтгүй тусламж нь хүнсний үйлдвэрлэлийн салбарын хөнгөлөлттэй хүүтэй зээл юм.

Засгийн газрын тусламжийн тайлант оны хөдөлгөөн дараах байдалтай байна:

Мянаан төгрөгөөр	Хөнгөлөлттэй хүүтэй зээл	Нийт
Өртөг		
01 дүгээр сарын 01-нээр	-	-
Авсан	1,501,315	1,501,315
Тайлант оны хорогдол	(375,324)	(375,324)
2024 оны 12 дугаар сарын 31-нээр	1,125,991	1,125,991
Урт хугацаат хэсэг	498,904	498,904
Богино хугацаат хэсэг	627,087	627,087

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

21 Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийн тохируулга

Дараах хүснэгтэд санхүүгийн үйл ажиллагааны өр төлбөрийн шинжилгээ, Группийн өр төлбөрийн өөрчлөлтийг тайлант хугацаа тус бүрээр харуулав. Эдгээр өр төлбөрүүд нь мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн үйл ажиллагааны хэсэгт тайлагнагдсан:

Мянган төгрөгөөр	Зээл	Түрээсийн өр төлбөр	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дүн	45,213,755	57,316,459	102,530,214
Мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	31,827,300	-	31,827,300
Үндсэн төлбөрийн эргэн төлөлт	(23,105,377)	(8,797,770)	(31,903,147)
Хүүгийн төлөлт	(6,805,263)	(10,292,530)	(17,097,793)
Мөнгөн бус гүйлгээ			
Шинэ түрээс	-	22,955,928	22,955,928
Түрээсийн гэрээг дуусгавар болгосон эсвэл дамжуулан түрээслэсэн	-	(2,772,762)	(2,772,762)
Хүүгийн зардал	6,963,076	10,292,530	17,255,606
Гадаад валютын ханшийн тохируулга	(241,530)	-	(241,530)
2023 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	53,851,961	68,701,855	122,553,816
Мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	63,371,715	-	63,371,715
Үндсэн төлбөрийн эргэн төлөлт	(66,526,553)	(13,085,709)	(79,612,262)
Хүүгийн төлөлт	(7,025,530)	(11,916,941)	(18,942,471)
Мөнгөн бус гүйлгээ			
Шинэ түрээс	-	31,003,367	31,003,367
Бизнесийн нэгдэл (Тодруулга 33)	3,017,100	1,294,881	4,311,981
Түрээсийн гэрээг дуусгавар болгосон эсвэл дамжуулан түрээслэсэн	-	(5,683,934)	(5,683,934)
Өр төлбөрийг эзэмшигчдийн өмчид хөрвүүлсэн	(5,120,900)	-	(5,120,900)
Хүүгийн зардал	6,944,180	11,916,941	18,861,121
Гадаад валютын ханшийн тохируулга	(389,500)	-	(389,500)
2024 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	48,122,473	82,230,460	130,352,933

22 Бусад татварын өглөг

Мянган төгрөгөөр	2024	2023
ХХОАТ-ын өглөг	1,353,681	982,002
НӨАТ-ын өглөг	325,174	422,447
Суутган татварын өглөг	176,224	127,714
Бусад татварын өглөг	283,847	137,435
12 дугаар сарын 31-ээрх нийт бусад татварын өглөг	2,138,926	1,669,598

Премиум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жил

23 Дансны ба бусад өглөг

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024	2023
Гуравдагч талуудад өгөх дансны өглөг		53,099,458	41,824,966
Холбоотой талуудад өгөх дансны өглөг	8	1,238,847	3,089,102
Гуравдагч талуудад өгөх бусад өглөг		5,580,405	1,694,248
Холбоотой талуудад өгөх бусад өглөг	8	1,557,428	31,119,181
Үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой өглөг		2,192,117	1,709,038
Дансны ба бусад өглөг дэх санхүүгийн өр төлбөр		63,668,255	79,436,535
Ажилчдад өгөх өглөг		3,231,481	1,730,365
Нийт бусад өглөг		3,231,481	1,730,365
12 дугаар сарын 31-ээрх нийт дансны ба бусад өглөг		66,899,736	81,166,900

Групп тайлант жилд Премиум Групп ХХК-д өгөх 30,000,000 мянган төгрөгийн бусад өглөгийг 144,231 мянган ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлсэн. Тодруулга 18-ыг харна уу.

Дансны ба бусад өглөгийн үлдэгдэл нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй.

24 Гэрээний өр төлбөр

Мянган төгрөгөөр	2024	2023
Лоялти оноо	997,565	779,096
Бэлгийн карт	237,878	445,840
Харилцагчдаас авсан урьдчилгаа	199,979	20,595
Роялти төлбөр	65,728	117,781
Нийт гэрээний өр төлбөр	1,501,150	1,363,312
Урт хугацаат хэсэг	43,388	117,781
Богино хугацаат хэсэг	1,457,762	1,245,531

Гэрээний өр төлбөр нь гэрээний үүрэг нь биелэх үед орлогоор хүлээн зөвшөөрөх франчайз эрх хүлээн авагчдаас урьдчилсан авсан роялти төлбөр, эцсийн хэрэглэгчдийн хэрэгжүүлээгүй байгаа лоялти оноо болон бэлгийн картаас ихэвчлэн бүрдсэн. Хэрэгжүүлээгүй байгаа лоялти оноо болон бэлгийн картын үлдэгдэл нь 1,235,443 мянган төгрөг (2023: 1,224,936 мянган төгрөг) байсан ба эдгээр нь энэхүү санхүүгийн тайлангийн өдрөөс нэг жилийн дотор орлогоор хүлээн зөвшөөрөгдөхөөр хүлээгдэж байна.

Франчайз эрх хүлээн авагчдаас 2023 онд урьдчилж авсан роялти төлбөрийн үлдэгдэл болох 74,393 мянган төгрөгийг 2024 онд орлогоор хүлээн зөвшөөрсөн (2023: 325,463 мянган төгрөг).

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх гэрээний өр төлбөрийн 1,224,936 мянган төгрөг нь 2024 оны тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн (2023: 583,259 мянган төгрөг).

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

25 Борлуулалтын орлого

Мянган төгрөгөөр	2024	2023
Эцсийн хэрэглэгчид бараа борлуулсны орлого	468,340,523	354,599,670
Франчайз эрх хүлээн авагчид бараа борлуулсны орлого	105,316,071	30,165,104
Франчайз эрх хүлээн авагчид үзүүлсэн үйлчилгээний орлого	21,340,692	5,454,053
Эцсийн хэрэглэгчид үзүүлсэн үйлчилгээний орлого	3,207,716	-
Брэнд нэр ашигласны эрхийн шимтгэлийн орлого	173,658	277,770
Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого	598,378,660	390,496,597

2024 онд дэлгүүрийн тоо 374-өөс 445 болж өссөнтэй холбоотойгоор эцсийн хэрэглэгчид бараа борлуулсны орлого 2024 онд ихээр нэмэгдсэн.

Орлого хүлээн зөвшөөрөх хугацаа (орлогын эх үүсвэр бүрээр) дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024	2023
Тухайн цаг хугацаанд	573,656,594	384,764,774
Хугацааны туршид	24,722,066	5,731,823
Нийт харилцагчтай байгуулсан гэрээний орлого	598,378,660	390,496,597

26 Борлуулалтын өртөг

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024	2023
Шууд материалын зардал*	15	364,516,060	256,813,791
Бараа материалын хорогдол	15	16,708,543	24,535,796
Шууд хөдөлмөрийн зардал**		53,268,549	47,595,537
Элэгдэл ба хорогдуулга	9, 10, 12	30,332,205	25,719,581
Түгээлтийн зардал		13,745,598	8,386,772
Ашиглалтын зардал		8,798,290	7,369,831
Лицензийн төлбөр		5,863,403	3,924,232
Богино хугацаат, бага үнэтэй хөрөнгийн түрээс болон түрээсийн хувьсах төлбөр		3,129,356	2,543,773
Банкны шимтгэл		2,407,369	1,674,383
Хангамжийн зардал		2,342,525	2,031,037
Засвар		1,716,058	944,394
Цэвэрлэгээ		1,370,158	1,108,805
Харуул, хамгаалалт		897,309	1,442,253
Бусад		13,177,363	9,272,435
Нийт борлуулалтын өртөг		518,272,786	393,362,620

* Шууд материалын зардалд холбоотой талуудаас худалдан авсан 15,743,675 мянган төгрөг (2023: 18,417,696 мянган төгрөг)-ийн бараа материал багтсан.

** Шууд хөдөлмөрийн зардалд нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 5,353,960 мянган төгрөг (2023: 4,647,922 мянган төгрөг) багтсан.

Премиум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жил

27 Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Хөдөлмөрийн зардал*	19,227,840	9,280,970
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр**	3,116,699	822,367
Маркетингийн зардал	3,210,980	1,668,429
Элэгдэл ба хорогдуулга	2,566,148	1,837,133
Харилцаа холбоо болон МТ-ийн зардал	1,583,805	1,084,273
Хүний нөөцтэй холбоотой зардал	948,291	345,317
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	702,070	77,469
Баяр ёслолын зардал	549,947	477,932
Сургалт хөгжүүлэлтийн зардал	220,130	432,205
Богино хугацаат болон бага үнэтэй хөрөнгийн түрээс	145,402	158,872
Бусад	2,531,794	945,639
Нийт ерөнхий ба захиргааны болон борлуулалтын зардал	34,803,106	17,130,606

* Хөдөлмөрийн зардалд нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 2,029,064 мянган төгрөг (2023: 1,079,782 мянган төгрөг) багтсан.

** Мэргэжлийн үйлчилгээний төлбөрт аудитын зардлын 384,828 мянган төгрөг (2023: 217,623 мянган төгрөг) багтсан.

28 Бусад олз, цэвэр

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Тохиролцоот худалдан авалтаас үүссэн олз (Тодруулга 33)	19,476,657	-
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	1,899,749	1,722,713
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	7,492	-
Хөрөнгө оруулалт борлуулсны олз	-	342,907
Бусад олз	698,480	1,133,807
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(105,233)	-
Гадаад валютын ханшийн олз/(гарз), цэвэр	45,856	(22,417)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	-	(27,867)
Бусад гарз	(158,987)	(94,483)
Нийт бусад олз, цэвэр	21,864,014	3,054,660

29 Санхүүгийн зардал

<i>Мянган төгрөгөөр</i>	2024	2023
Түрээсийн хүүгийн зардал	11,916,941	10,292,530
Зээлийн хүүгийн зардал	6,944,180	6,963,076
Бусад санхүүгийн зардал	577,058	250,877
Ашиг, алдагдалд бүртгэгдсэн нийт санхүүгийн зардал	19,438,179	17,506,483

Премиум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жил

30 Санхүүгийн орлого

Мянган төгрөгөөр	2024	2023
Зээлтэй холбоотой гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, цэвэр	389,500	241,530
Түрээсийн авлагын хүүгийн орлого	2,016,301	879,968
Банк дахь бэлэн мөнгө болон хадгаламжийн хүүгийн орлого	139,314	14,269
Бусдад олгосон зээлийн хүүгийн орлого	17,262	848
Нийт санхүүгийн орлого	2,562,377	1,136,615

31 Орлогын албан татвар

(а) Орлогын албан татварын зардал/(өгөөж)-ын бүрэлдэхүүн хэсгүүд

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн орлогын татварын зардал дараах бүрэлдэхүүнтэй байна:

Мянган төгрөгөөр	2024	2023
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	3,502,969	61,206
Хойшлогдсон татварын өгөөж	(553,012)	(687,117)
Тайлант жилийн орлогын албан татварын зардал / (өгөөж)	2,949,957	(625,911)

(б) Татварын зардал ба ашиг алдагдлыг ногдох татварын хувиар үржүүлсэн тооцооллын тохируулга

Хуулиар тогтоосон хувь хэмжээгээр татварын өмнөх ашиг/алдагдлаас тооцож гаргасан орлогын татварын зардал болон Группд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардал хоорондын тохируулга дараах байдалтай.

Мянган төгрөгөөр	2024	2023
Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал)	50,352,451	(33,332,214)
Хуулиар заасан хувиар тооцсон татвар:	11,688,113	(3,333,221)
Татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардлын нөлөө:		
– Хасагдахгүй зардал	(5,232,044)	1,896,915
– Өмнөх үеийн татварын алдагдлын тохируулга	829,518	749,189
– Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлого	(51,460)	61,206
– Татвар ногдохгүй орлого	(440,197)	-
– Алдагдал шилжүүлэлт	(3,708,687)	-
– Татварын хөнгөлөлт	(135,286)	-
Тайлант жилийн орлогын албан татварын зардал/(өгөөж)	2,949,957	(625,911)

СТОУС болон Монгол Улсын татварын зохицуулалтын зөрүүнээс болж хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын суурь хооронд түр зөрүү үүсдэг.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

31 Орлогын албан татвар (Үргэлжлэл)

(в) Татварын алдагдлын шилжүүлэг

Группийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хасагдах түр зөрүүтэй холбоотой хүлээн зөвшөөрөөгүй боломжит хойшлогдсон татварын хөрөнгө 2,626,795 мянган төгрөг (2023: 587,347 мянган төгрөг) байна. Группийн баталгаажсан татварын алдагдлыг дараагийн тайлант хугацаануудад шилжүүлэх хуваарь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024	2023
Татварын алдагдлын шилжүүлэг – дуусах огноогоор:		
- 2024 оны 12 дугаар сарын 31	-	13,000,593
- 2025 оны 12 дугаар сарын 31	10,301,855	13,701,935
- 2026 оны 12 дугаар сарын 31	7,491,892	7,491,892
- 2027 оны 12 дугаар сарын 31	26,267,950	26,267,950
12 дугаар сарын 31-ээрх татварын алдагдлын шилжүүлэг	44,061,697	60,462,370

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол Улсын татварын хуулинд оруулсан татварын алдагдал шилжүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Татварын алдагдлын шилжүүлэг 4 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай. Тухайн жилд ашиглах боломжтой татварын алдагдлын шилжүүлэг нь жилийн татвар ногдох орлогын 50 хувиас хэтрэхгүй.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн түр зөрүүний өөрчлөлт, хөдөлгөөнөөс Группд үүссэн татварын нөлөө:

Мянган төгрөгөөр	2023	Орлого үр дүнгийн тайланд бүртгэсэн	Тохиролцоот худалдан авалтаас үүссэн олзоор бүртгэсэн	2024
Үндсэн хөрөнгө	450,459	575,195	-	1,025,654
Ашиглах эрхтэй хөрөнгө	924,090	(82,581)	-	841,509
Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй зөрүү	51,796	39,481	-	91,277
Үндсэн хөрөнгө	(259,446)	20,917	(1,111,287)	(1,349,816)
Биет бус хөрөнгө	-	-	(3,221,962)	(3,221,962)
Хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)	1,166,899	553,012	(4,333,249)	(2,613,338)

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн түр зөрүүний өөрчлөлт, хөдөлгөөнөөс Группд үүссэн татварын нөлөө:

Мянган төгрөгөөр	2022	Орлого үр дүнгийн тайланд бүртгэсэн	2023
Үндсэн хөрөнгө	238,090	212,369	450,459
Ашиглах эрхтэй хөрөнгө	470,752	453,338	924,090
Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй зөрүү	58,533	(6,737)	51,796
Үндсэн хөрөнгө	(287,593)	28,147	(259,446)
Хойшлогдсон татварын хөрөнгө	479,782	687,117	1,166,899

32 Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг/(алдагдал)-ийг тооцоолохдоо Группийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг/(алдагдал)-ийн дүнг тайлант хугацаанд эргэлтэд байсан хувьцааны (халаасны хувьцаанаас бусад) жинлэсэн дундаж тоонд харьцуулан гаргадаг.

Үндсэн үйл ажиллагааны нэгж хувьцаанд ногдох ашгийн тооцоолол:

Мянган төгрөгөөр	2024	2023
Энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах тайлант жилийн ашиг/(алдагдал)	46,598,361	(32,706,303)
Эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж (мянган ширхэг)	1,097,809	817,769
Нэгж энгийн хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан ашиг/(алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	42.45	(39.99)

Групп нь хорогдуулах боломжит энгийн хувьцаагүй тул нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг нь нэгж хувьцаанд ногдох ашигтай тэнцүү байна.

33 Бизнесийн нэгдэл

2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Групп нь Чингис Шар Айраг ХХК-ийн 90%, Сэнтрал Коммерс ХХК-ийн 100%, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК-ийн 100% болон Стора Централ ХХК-ийн 65.9%-ийн хувьцааг худалдан авсан. Энэхүү худалдан авалтыг Групп стратегийн хөрөнгө оруулагчдад нэмэлт энгийн хувьцаа гаргах замаар гүйцэтгэсэн. Энэхүү худалдан авалт нь Группийн урт хугацааны өсөлтийн зорилтуудад нийцсэн, өөрийн үндсэн үйл ажиллагаатай нийцдэг бизнесүүдийг өөртөө нэгтгэн үнэ цэнэ бүтээх зорилгоор хийж буй стратегийн алхам юм.

Групп нь худалдан авсан компаниуд дах хяналтын бус хувь оролцоог тодорхойлогдох цэвэр хөрөнгийн хувь тэнцүүлсэн хэмжээгээр тооцохоор сонгосон.

(а) Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөр

Худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн худалдан авалтын төлбөрүүдийг дараах хүснэгтэд нэгтгэсэн:

Мянган төгрөгөөр	Чингис Шар Айраг ХХК	Сэнтрал Коммерс ХХК	Сэнтрал Кофе Рөүстинг ХХК	Стора Централ ХХК	Нийт
Гаргасан энгийн хувьцаа	21,510,000	2,035,970	1,867,433	1,134,243	26,547,646
Нийт төлбөр	21,510,000	2,035,970	1,867,433	1,134,243	26,547,646

(б) Худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө ба тогтоосон өр төлбөр

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, бусад хөрөнгө болон өр төлбөрүүдийн бодит үнэ цэний хэмжилтийг хараат бус үнэлгээний компаний гүйцэтгэсэн.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

33 Бизнесийн нэгдэл (Үргэлжлэл)

(б) Худалдан авсан тодорхойлох хөрөнгө ба тогтоосон өр төлбөр (үргэлжлэл)

Бизнесийн нэгдлийн өдрөөр худалдан авсан хөрөнгө ба тогтоосон өр төлбөрийн бодит үнэ цэнийг дараах хүснэгтэд нэгтгэв:

Мянган төгрөгөөр	Чингис Шар Айраг ХХК	Сэнтрал Коммерс ХХК	Сэнтрал Кофе Рөүстинг ХХК	Стора Централ ХХК	Нийт
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	496,720	253,751	24,426	77,666	852,563
Дансны ба бусад авлага	1,681,305	1,421,396	544,132	762,556	4,409,389
Урьдчилгаа	769,204	152,225	12,206	110,288	1,043,923
Бараа материал	832,784	3,732,324	116,260	-	4,681,368
Үндсэн хөрөнгө	17,939,506	332,565	1,063,143	266,327	19,601,541
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	882,926	235,213	176,742	1,294,881
Биет бус хөрөнгө	32,233,697	23,999	-	564,549	32,822,245
Бусад эргэлтийн бус хөрөнгө	40,000	110,297	69,291	-	219,588
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	2,304	1,082	-	3,386
Дансны ба бусад өглөг	(3,208,671)	(1,109,281)	(97,113)	(165,194)	(4,580,259)
Гэрээний өр төлбөр	(9,377)	(2,187)	-	(49,323)	(60,887)
Зээл	-	(3,017,100)	-	-	(3,017,100)
Орлогын албан татварын өглөг	(154,867)	-	-	-	(154,867)
Бусад татварын өглөг	(264,850)	(11,312)	(2,612)	(12,071)	(290,845)
Түрээсийн өр төлбөр	-	(1,144,372)	(238,368)	(184,101)	(1,566,841)
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	-	-	(8,344)	(8,344)
Нийт	50,035,451	1,627,535	1,727,660	1,539,095	55,249,741
Хяналтын эрхгүй хувь оролцоо	5,035,545	-	-	524,831	5,560,376
Бодит үнэ цэнийн өсөлтийн хойшлогдсон татварын өр	4,333,249	-	-	-	4,333,249
Худалдан авалтаарх гүүдвил	-	408,435	139,773	119,978	668,186
Нэгтгэсэн ашиг, алдагдлын тайланд бусад олзоор хүлээн зөвшөөрсөн тохиролцоот худалдан авалтаас үүссэн олз	(19,476,657)	-	-	-	(19,476,657)
Энгийн хувьцаа гаргаж төлсөн нийт төлбөр	21,510,000	2,035,970	1,867,433	1,134,242	26,547,645

Групп Чингис Шар Айраг ХХК-ийн 90%, Сэнтрал Коммерс ХХК-ийн 100%, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК-ийн 100% болн Стора Централ ХХК-ийн 65.9%-ийн хувьцааг 127,563,909 ширхэг нэмэлт энгийн хувьцаа гарган худалдан авсан. Шинээр гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 208 төгрөг байна.

Худалдан авалтын өдрөөрх дансны ба бусад авлагын бодит үнэ цэн нь 4,409,388 мянган төгрөг байсан. Дансны авлагын нийт дүн нь 4,409,388 мянган төгрөг байсан ба гэрээний нийт дүн нь буцаан төлөгдөнө гэж үзэж байна.

33 Бизнесийн нэгдэл (Үргэлжлэл)

(б) Худалдан авсан тодорхойлодох хөрөнгө ба тогтоосон өр төлбөр (үргэлжлэл)

Энэхүү бизнес нэгдэлтэй холбоотойгоор 82,793 мянган төгрөгийн ажил гүйлгээний зардал гарсан. Энэ зардал нь эздийн өмчийн нэмж төлөгдсөн капиталаас хасагдаж бүртгэгдсэн.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдлын тайланд 19,476,657 мянган төгрөгийн тохиролцоот худалдан авалтаас үүссэн олзыг бусад олзоор хүлээн зөвшөөрөгдсөн.

(в) Бодит үнэ цэнийн хэмжилт

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг хөндлөнгийн үнэлгээний компани хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний мэргэжилтэн нь Монголын мэргэшсэн үнэлгээний институтын мэргэшсэн үнэлгээчин юм.

Хөрөнгө	Үнэлгээний аргачлал
Үндсэн хөрөнгө	Уг үнэлгээний загвар нь зах зээлийн жишиг үнэ байгаа үед ижил төрлийн зүйлсийн зах зээлийн үнийг, мөн тохиромжтой үед хорогдуулсан орлуулалтын өртгийг авч үздэг. Хорогдуулсан орлуулалтын өртөг нь биет хоцрогдол болон хуучралт, мөн үйл ажиллагааны болон эдийн засгийн хоцрогдол зэргийг авч үздэг.
Тодорхойлогдох биет бус хөрөнгө	Үнэлгээний арга нь худалдааны нэрний нийт мөнгөн урсгалын одоогийн үнэ цэнийг тооцоолдаг ба тухайн мөнгөн урсгалаас бусад туслах хөрөнгүүдтэй холбоотой мөнгөн урсгалыг хасдаг.

Премшум Нэксус ХК
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

34 Хяналтын эрхгүй хувь оролцоо

Дараах хүснэгтэд Группийн компани хоорондын ажил гүйлгээг устгахаас өмнөх материаллаг хяналтын бус хувь оролцоо бүхий охин компани тус бүрийн мэдээллийг товчлон харуулав:

Мянган төгрөгөөр	Чингис Шар Айраг ХХК	Сэнтрал Коммерс ХХК	Сэнтрал Кофе Рөүстинг ХХК	Стора Централ ХХК	Нийт
Хяналтын эрхгүй хувь оролцооны хувь	16.8%	16.8%	9.1%	34.1%	
Эргэлтийн хөрөнгө	3,594,970	13,746,607	2,652,037	1,017,806	21,011,420
Эргэлтийн бус хөрөнгө	51,197,958	2,071,252	1,178,051	1,199,283	55,646,544
Эргэлтийн өр төлбөр	(599,461)	(11,751,003)	(1,719,690)	(765,613)	(14,835,767)
Эргэлтийн бус өр төлбөр	-	(34,003)	(2)	(64,560)	(98,565)
Цэвэр хөрөнгө	54,193,467	4,032,853	2,110,396	1,386,916	27,006,822
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох цэвэр хөрөнгө*	7,165,063	181,544	181,818	540,819	8,069,244
Орлого	10,293,289	32,907,435	3,525,548	2,663,457	49,389,729
Ашиг/(алдагдал)	2,697,963	2,223,775	382,736	(165,762)	5,138,712
Нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)	2,697,963	2,223,775	382,736	(165,762)	5,138,712
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох ашиг/(алдагдал)	452,718	373,149	34,791	(56,525)	804,133

*2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Групп Чингис Шар Айраг ХХК болон түүний бүрэн эзэмшлийн охин компани болох Чингис Шар Айраг Клуб ХХК-ийг худалдан авсан. Худалдан авалтын үеийн хяналтын эрхгүй хувь оролцоо 10% буюу 5,035,545 мянган төгрөг байсан (Тодруулга 33-ыг харна уу). 2024 оны 02 дугаар сард Групп нэмж 6.8%-ийг гуравдагч талд борлуулж, хяналтын эрхгүй хувь оролцоог 2,367,049 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Групп Сэнтрал Коммерс ХХК-ийн 100%-ийн хувьцааг худалдан авсан. 2024 оны 2 дугаар сард Групп 16.8%-ийг гуравдагч талд борлуулж, хяналтын эрхгүй хувь оролцоог 181,544 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Групп Сэнтрал Кофе Рөүстинг ХХК-ийн 100%-ийн хувьцааг худалдан авсан. 2024 оны 2 дугаар сард Групп 9.1%-ийг гуравдагч талд борлуулж, хяналтын эрхгүй хувь оролцоог 181,818 мянган төгрөг болгосон.

35 Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг. Бизнесийн үйл ажиллагааны явцад Группийн эсрэг зарга үүсэх боломжтой. Удирдлага өөрсдийн хийсэн тооцоололд үндэслэн эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад тусгагдсан нөөц сангаас илүү дүнгээр материаллаг хэмжээний алдагдал учрахгүй гэж үзэж байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн эсрэг ямар нэгэн шүүхийн нэхэмжлэл ирээгүй тул Группийн удирдлага ирээдүйд мэдэгдэхүйц хэмжээний их алдагдал үүсэхгүй гэж үзэн болзошгүй өр төлбөртэй холбоотойгоор эрсдэлийн нөөц санг байгуулаагүй болно.

Татварын болзошгүй өглөг. Монгол Улсын татвар, валют болон гаалийн тухай хуулиудын талаарх ойлголтууд нь ялгаатай байх тохиолдлууд байдаг ба тэдгээр хуулиуд нилээд өөрчлөгдөж байдаг. Эдгээр хуулиудыг удирдлага нь Группийн ажил гүйлгээ, үйл ажиллагаанд өөрсдийн ойлголт, тайлбарын хүрээнд хэрэгжүүлж байгаа боловч аливаа татварын эрх бүхий байгууллагуудын сорилттой тулгарч болно. Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсч байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 (2019 он хүртэл: 5 жил байсан) жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан хэдий ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурилсан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтанд байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх төлөвлөгөө, горимыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын татварын хууль тогтоомжуудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Групп нь үе үе татварын ерөнхий хувь хэмжээг бууруулах ийм тодорхойгүй байдалтай тулгардаг. Одоогийн байдлаар удирдлагын зүгээс татварын байр суурь, тайлбарыг тогтвортой байлгах боломжтой гэж тооцож байгаа боловч татварын алба эдгээр татварын байр суурь, тайлбарыг эсэргүүцэх тохиолдолд нэмэлт татвар төлөх эрсдэлтэй болно. Ийм сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй боловч энэ нь Группийн санхүүгийн байдал болон/эсвэл үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

Гэрээний үүргийг дагаж мөрдөх. Групп авсан зээлтэй холбоотойгоор зарим үүргийн биелэлтийг хангах ёстой. Зээлийг хугацаандаа эргэн төлдөг тохиолдолд, үүргийн биелэлтийг хангахгүй байх нь Группд сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй, мөн төлбөрийн чадварын эрсдэл нэмэгдэх эрсдэлтэй. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Групп бүх үүргийн гүйцэтгэлийг хангасан.

36 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Групп доторх эрсдэлийн удирдлагын чиг үүрэг нь санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл болон хууль эрх зүйн эрсдэлд хамаардаг. Санхүүгийн эрсдэл нь зах зээлийн эрсдэл (үүнд гадаад валютын ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл багтана), зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэлээс бүрдэнэ. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн чиг үүрэг нь эрсдэлийн хязгаарлалтыг тогтоож, уг хязгаарлалтад эрсдэлийн түвшинд барих явдал юм. Үйл ажиллагааны болон хууль эрх зүйн эрсдэлийн удирдлагын чиг үүрэг нь тухайн эрсдэлийг багасгахын тулд дотоод бодлого, журмын зохистой хэрэгжилтийг хангаж ажиллахад чиглэнэ.

Зээлийн эрсдэл. Групп зээлийн эрсдэлд өртдөг бөгөөд энэ нь санхүүгийн хэрэглүүрт нэг тал хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс нөгөө тал санхүүгийн алдагдал үүрэх эрсдэл юм.

Харилцагч талуудтай хийсэн зээлийн болон бусад ажил гүйлгээний үр дүнд Группийн зээлийн эрсдэлд өртөх магадлал нэмэгдэж байдаг бөгөөд санхүүгийн хөрөнгө болон зээлтэй холбоотой балансын гадуурх үүрэг амлалтыг бий болгож байдаг.

36 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Группийн зээлийн эрсдэлд хамгийн ихээр өртөж болох дүн нь санхүүгийн байдлын тайлан дээрх холбогдох санхүүгийн хөрөнгийн дансны дүнд тусгагддаг.

Группийн зээлийн эрсдэлд хамгийн ихээр өртөж болох дүнгүүдийг санхүүгийн хөрөнгийн дансны нийт дүнд тусган харууллаа:

Мянган төгрөгөөр	2024	2023
Дансны болон бусад авлага (Тодруулга 16)		
- Дансны авлага	6,823,020	613,789
- Бусад санхүүгийн авлага	3,218,328	3,086,231
Санхүүгийн түрээсийн авлага (Тодруулга 12)		
- Санхүүгийн түрээсийн авлага	13,151,106	9,741,193
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Тодруулга 17)		
- Банкны харилцах дансанд буй мөнгөн хөрөнгө	9,871,019	2,139,691
Зээлийн авлага (Тодруулга 13)	74,648	2,000,000
Нийт зээлийн эрсдэлд хамгийн их өртөх дүн	33,138,121	17,580,904

Зээлийн эрсдэлийн удирдлага. Зээлийн эрсдэл нь Группийн бизнесийн үйл ажиллагааны хамгийн том эрсдэл юм; тиймээс удирдлага зээлийн эрсдэлийг сайтар хянадаг.

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем. Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэглүүрийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Групп хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагуудын (Стандарт энд Пүүр'с - "S&P", Фитч, Мүүди'с) гаргасан эрсдэлийн үнэлгээг үндэслэсэн аргачлалыг ашигладаг. Гаднын болон дотоод эрсдэлийн үнэлгээг дотооддоо тодорхойлогдсон үнэлгээний үндсэн хэмжүүрийг төлбөр төлөгдөхгүй болох магадлалын тодорхой хязгаартай уялдуулан харуулсныг дараах хүснэгтэд тусгасан:

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр	Хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагын үнэлсэн харгалзах зэрэг (Стандарт энд Пүүр'с)	Төлбөрийн чадваргүй болох магадлалын харгалзах интервал
Маш сайн	AAA to BB+	0.01% – 0.5%
Сайн	BB to B+	0.51% – 3%
Хангалттай	B, B-	3% – 10%
Анхаарал татсан	CCC+ to CC-	10% – 99.9%
Үнэ цэнийн бууралттай	C, D-I, D-II	100%

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- Маш сайн - хүлээгдэж буй зээлийн эрсдэл багатай, чанартай зээл;
- Сайн - дунд зэргийн зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар хангалттай;
- Хангалттай - хангалттай зээлийн эрсдэлтэй, зээлийн чанар дунд зэрэг;
- Анхаарал татсан - удирдлага илүү ойр ойрхон хяналт тавьж, арга хэмжээ авах шаардлагатай;
- Үнэ цэнийн бууралттай, дефолт буюу төлбөр төлөгдөхгүй болох - төлбөрийн чадваргүй болсон хэрэгслүүд.

Хөндлөнгийн зэрэглэлийн үнэлгээг Стандарт энд Пүүр'с, Мүүди'с, Фитч зэрэг хөндлөнгийн хараат бус олон улсын үнэлгээний байгууллагууд гаргадаг. Эдгээр үнэлгээ нь олон нийтэд нээлттэй байдаг.

36 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь ирээдүйн бэлэн мөнгөний алдагдлын өнөөгийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жинлэсэн тооцоолол (өгөгдсөн хугацаанд төлбөр төлөгдөхгүй болох эрсдэлээр жинлэсэн эрсдэлийн алдагдлын жинлэсэн дундаж) юм.

ХБЭА хэмжилт нь олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлогддог. ХБЭА-ын хэмжилтийг Группийн хэрэглэдэг дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэслэн тогтооно: Үүнд төлбөр төлөгдөхгүй болох магадлал (PD), төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн (EAD), төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ (LGD) (төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ) болон дискаунтын хувь (DR) орно.

Төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүн гэдэг нь тайлант хугацааны дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг авч үзэн зээлдэгч ирээдүйд төлбөр төлөгдөхгүй болох үед хэдий хэмжээний өр (үндсэн зээл болон хүүгийн эргэн төлөлтийг оруулан)-тэй байх таамаглал юм. Төлбөр төлөгдөхгүй болох магадлал гэдэг нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд төлбөр төлөгдөхгүй болох магадлалыг тооцоолдог. Төлбөр төлөгдөхгүй болсон үеийн алдагдлын хэмжээ гэдэг нь төлбөр төлөгдөхгүйгээс болж үүссэн алдагдлын тооцоолол юм. Үүнийг төлөх ёстой гэрээний мөнгөн урсгал болон зээлдүүлэгчийн барьцаа хөрөнгөөс гарах мөнгийг оролцуулан хүлээж буй мөнгөн дүн хоёрын зөрүүнд үндэслэнэ. Ихэвчлэн төлбөр төлөгдөхгүй болсон үеийн дүнгийн хувиар илэрхийлдэг. Хүлээгдэж буй алдагдал нь тайлант хугацааны эцэст дискаунтчилагдан өнөөгийн үнэ цэнээр бүртгэгддэг. Дискаунтын хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшингээр, ойролцоогоор тодорхойлогдоно.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь хэрэглүүрийн хугацааны туршид загварчлагдсан. Хугацааны турш гэдэг нь гэрээний үлдсэн хугацаа буюу өрийн хэрэглүүрийн дуусгавар болох өдөр хүртэл үргэлжилнэ (хүлээгдэж буй урьдчилж төлсөн төлбөр залруулагдсан бол).

Удирдлага хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг загварчилдаг ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын үлдэх хугацааны туршид үүсэж болзошгүй бүх тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаа нь нэг жилээс бага байгаа бол санхүүгийн хэрэглүүрт тохиолдох болзошгүй үйл явдлаас үүссэн ашиглалтын хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын ногдох хэсгийг илэрхийлнэ.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагаас үнэлдэг ХБЭА нь тухайн цаг хугацааны тооцоолол байдаг. Тооцоололд ирээдүйд чиглэсэн мэдээллийг буюу зээлийн эрсдэлд нөлөөлөх макро эдийн засгийн гол хувьсагчдын жинлэсэн магадлалын дүнг ХБЭА-д тусгасан эсэхийг авч үздэг.

Групп дефолт болох магадлалыг тооцоолохдоо доор дурдсан нөхцөлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- зээлдэгч гэрээний дагуу төлөх ёстой төлбөрөө төлөхгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- олон улсын үнэлгээний байгууллагуудаас зээлдэгчийг дефолт буюу төлбөр төлөгдөхгүй болох ангилалд ангилсан;
- зээлдэгч доор дурдсан төлбөрийн тааламжгүй байдлын шалгуурыг хангасан бол:
 - зээлдэгч нь нас барсан;
 - зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон;
 - зээлдэгч нь санхүүгийн үүргээ зөрчсөн;
 - зээлдэгч дампуурах магадлал өндөр болох тохиолдолд.

Тодруулгын зорилгоор Групп нь төлбөр төлөгдөхгүй байх тодорхойлолтыг үнэ цэн буурсан хөрөнгийн тодорхойлолттой бүрэн нийцүүлсэн. Дээр дурдсан төлбөр төлөгдөхгүй байх тодорхойлолт нь Группийн бүх төрлийн санхүүгийн хөрөнгийн хувьд ашиглагдана.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR) байгаа эсэх үнэлгээг тухайн санхүүгийн хэрэглүүр тус бүрийн хувьд хийнэ. 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн санхүүгийн хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт байсан гэсэн таамаглалыг няцаагаагүй болно.

36 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Зах зээлийн эрсдэл. Групп нь зах зээлийн эрсдэлийн нөлөөлөлд үйл ажиллагаагаа явуулдаг. Зах зээлийн эрсдэл нь (а) валютын ханш, (б) хүүгийн түвшин ба (в) өмчийн хэрэглүүр гэх мэт зах зээлийн ерөнхий болон тусгай хувьсагчуудын хэлбэлзлийн улмаас үүсдэг. Удирдлага хүлээн зөвшөөрөгдөж болох эрсдэлийн үнэнд хязгаарыг тогтоох замаар өдөр тутам хяналт тавьдаг. Гэхдээ тухайн хязгаараас давсан, зах зээлд мэдэгдэхүйц их хэмжээний өөрчлөлт үүсвэл энэхүү арга нь алдагдал хүлээх эрсдэлээс хамгаалж чадахгүй.

Гадаад валютын ханшийн эрсдэл. Гадаад валютын ханшийн эрсдэлийн тухайд удирдлага нь өдөр тутам хянаж байдаг өдрийн болон шөнийн байдлаарх нийт дүнд болон валют өртөлтийн хэмжээнд хязгаарлалтыг тогтоодог.

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцэс дэх Группийн гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх дүнг хураангуйлан харуулав:

Мянган төгрөгөөр	2024				
	Ам доллар	Вон	Юань	Евро	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	143,499	9,339	-	6,314	159,152
Нийт санхүүгийн хөрөнгө	143,499	9,339	-	6,314	159,152
Санхүүгийн өр төлбөр					
Дансны ба бусад өглөг	7,324,681	899,740	35,009	-	8,259,430
Зээл	-	2,063,762	-	-	2,063,762
Нийт санхүүгийн өр төлбөр	7,324,681	2,963,502	35,009	-	10,323,192

Мянган төгрөгөөр	2023			
	Ам доллар	Вон	Евро	Нийт дүн
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	41,016	481,046	764	522,826
Нийт санхүүгийн хөрөнгө	41,016	481,046	764	522,826
Санхүүгийн өр төлбөр				
Дансны ба бусад өглөг	1,136,915	2,108,104	171,225	3,416,244
Зээл	-	8,075,713	-	8,075,713
Нийт санхүүгийн өр төлбөр	1,136,915	10,183,817	171,225	11,491,957

Дээр дурдсан шинжилгээнд зөвхөн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрүүд орно. Эздийн өмчийн хөрөнгө оруулалт ба мөнгөн бус хөрөнгө нь аливаа валютын материаллаг эрсдэлийг үүсгэдэггүй гэж үздэг.

Премиум Нэксус ХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

36 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд Группийн бүртгэлийн валюттай холбоотой тайлант хугацааны эцэст ашигласан ханш боломжит үндэслэлээр өөрчлөгдөхөд (бусад бүх хувьсагч тогтмол байхад) ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд нөлөөлөх мэдрэмжит байдлыг харуулав:

	2024 оны 12 дугаар сарын 31		2023 оны 12 дугаар сарын 31	
<i>Мянган төгрөгөөр</i>	Ашиг алдагдалд үзүүлэх нөлөө	Эзэмшигчдийн өмчид үзүүлэх нөлөө	Ашиг алдагдалд үзүүлэх нөлөө	Эзэмшигчдийн өмчид үзүүлэх нөлөө
Ам доллар 5%-аар чангарсан үед	(359,059)	(359,059)	(54,795)	(54,795)
Ам доллар 5%-аар суларсан үед	359,059	359,059	54,795	54,795
Вон 5%-аар чангарсан үед	(147,708)	(147,708)	(485,139)	(485,139)
Вон 5%-аар суларсан үед	147,708	147,708	485,139	485,139
Юань 5%-аар чангарсан үед	(1,750)	(1,750)	-	-
Юань 5%-аар суларсан үед	1,750	1,750	-	-
Евро 5%-аар чангарсан үед	316	316	(8,523)	(8,523)
Евро вон 5%-аар суларсан үед	(316)	(316)	8,523	8,523

Хөрвөх чадварын эрсдэл. Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Групп санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд учрах хүндрэлтэй холбоотой эрсдэл юм. Групп мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээсээ өдөр тутмын төлбөр тооцоогоо хийх хэрэгтэй болдог.

Групп нь мөнгөн хөрөнгийн хангалттай үлдэгдэл, боломжит зээлийн хязгаарыг хадгалах, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын урьдчилсан тооцоо болон бодит дүнг тогтмол хянах, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн төлөгдөх хугацааны шинжилгээг хийх замаар төлбөрийн чадвараа удирддаг.

Дараах хүснэгтэд Группийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өр төлбөрийн дүнг гэрээнд заасан төлөх хугацааны үлдсэн хугацаагаар харуулав. Төлбөрийн дуусгавар болох хугацааг харуулсан хүснэгтэд тусгагдсан дүн нь гэрээний дагуу дискаунт тооцоогүй мөнгөн гүйлгээ бөгөөд ийм дискаунт тооцоогүй мөнгөн гүйлгээ нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дүнгээс ялгаатай тул санхүүгийн байдлын тайлангийн дүн нь дискаунтлагдсан мөнгөн гүйлгээнд суурилдаг.

Төлбөрийн хэмжээ хувьсах шинжтэй тохиолдолд тайлант хугацааны эцэс дэх оршин байгаа нөхцөл байдлыг харгалзан тодруулсан дүнг тодорхойлно. Гадаад валютын төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшийг ашиглан хөрвүүлдэг.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн өр төлбөрийн төлөгдөх хугацааны шинжилгээ дараах байдалтай байна:

<i>Мянган төгрөгөөр</i>	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар хүртэл	6-12 сар хүртэл	1 - 5 жил хүртэл	Нийт дүн
Дансны ба бусад өглөг (Тодруулга 23)	35,895,624	14,574,401	13,198,230	-	63,668,255
Зээл – гуравдагч тал (Тодруулга 19)	13,332,071	7,096,319	7,950,312	25,482,839	53,861,541
Зээл – холбоотой тал (Тодруулга 19)	9,833	47,282	49,131	2,221,809	2,328,055
Түрээсийн өр төлбөр (Тодруулга 10)	1,942,254	9,718,883	11,633,064	90,161,720	113,455,921
Нийт ирээдүйд төлөх төлбөр /ирээдүйн үндсэн болон хүүгийн төлбөрийн хамт/	51,179,782	31,436,885	32,830,737	117,866,368	233,313,772

37 Капиталын удирдлага

Группийн капиталын удирдлагын үндсэн зорилго нь хувьцаа эзэмшигчдийг өгөөжтэй, бусад нөлөө бүхий талуудыг үр ашигтай байлгах болон капиталын бүтцийг илүү тохиромжтой, зардал багатай байдлаар зохион байгуулахын тулд Группийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад оршино. Капиталын бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Групп нь хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг буцаах, шинэ хувьцаа гаргах эсвэл зээлийг бууруулах зорилгоор хөрөнгөө худалдах боломжтой. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн өөрийн хөрөнгийн нийт хэмжээ нь 102,788,809 мянган төгрөг (2023: 14,268,682 мянган төгрөгийн сөрөг утгатай) байсан.

38 Бодит үнэ цэнийн тодруулга

Бодит үнэ цэнээр хэмжихдээ бодит үнэ цэнийн шатлалын түвшингээр дараах бүлэгт хуваан үздэг: (i) түвшин 1 нь тухайн хөрөнгө болон өр төлбөрийн хувьд идэвхтэй зах зээл дээр зарлагдсан үнэ (залруулаагүй); (ii) түвшин 2 нь хөрөнгө болон өр төлбөрийн бүх материаллаг, ажиглагдахуйц шууд (үнээр) болон шууд бус (үнээс үүссэн) бүх өгөгдлүүдийг ашиглан тооцоолдог үнэлгээний арга; (iii) түвшин 3 нь зах зээл дээр ажиглаж болохоор мэдээлэлд тулгуурладаггүй үнэлгээ юм (ажиглагдахуйц бус өгөгдөл). Удирдлага бодит үнэ цэнийн шатлалыг ашиглан санхүүгийн хэрэглүүрүүдийг ангилахдаа өөрсдийн үнэлэмжийг ашигладаг. Хэрэв бодит үнэ цэнийн хэмжилтэнд томоохон залруулга хийгдэх ажиглагдахуйц өгөгдлүүд хэрэгтэй бол түвшин 3-аар тооцоолдог. Үнэлгээнд оролцож буй өгөгдлүүдийн нөлөөг бодит үнэ цэнийн хэмжилтийн нийт дүнд эзлэх хэмжээгээр үнэлдэг.

39 Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн ангиллаарх толилуулга

Хэмжилтийн зорилгоор СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-д санхүүгийн хөрөнгийг дараах ангилалд ангилдаг: (а) ашиг алдагдлаарх бодит үнэ цэн бүхий санхүүгийн хөрөнгө; (б) ашиг алдагдлаарх бодит үнэ цэн бүхий өрийн хэрэглүүр, (в) ашиг алдагдлаарх бодит үнэ цэн бүхий өмчийн хэрэглүүр, (в) хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилна. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэн бүхий санхүүгийн хөрөнгө нь хоёр дэд ангилалтай: (i) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр заавал хэмжигдэх хөрөнгө, (ii) анх хүлээн зөвшөөрөгдсөн үед ийм байдлаар тодорхойлогдсон хөрөнгө. Түүнчлэн санхүүгийн түрээсийн авлага нь тусдаа ангиллыг бүрдүүлдэг.

40 Тайлант хугацааны дараах үйл явдал

2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр, Групп нь түгээлтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Голомт Банктай жилийн 15 хувийн хүүтэй 1,116,145 мянган төгрөгийн санхүүгийн түрээсийн гэрээ байгуулсан.

2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр, Групп нь Голомт Банктай жилийн 15 хувийн хүүтэй 7,164,800 мянган төгрөгийн зээлийн гэрээ байгуулсан.

41 Орчуулга

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол, Англи хоёр хэлээр бэлтгэсэн бөгөөд Монгол хэлээрх, Англи хэлээрх хоёр хувилбарын хооронд утгын зөрүү гарсан тохиолдолд Англи хэлээрх хувилбарыг баримтална.